



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ БИЙ БОЛГОХ, АШИГЛАХ



Улаанбаатар
2023 он

ЗАХИАЛАГЧ:

Үндэсний статистикийн хороо

БЭЛТГЭЖ БОЛОВСРУУЛСАН:

А.Солонго, Жендэрийн үндэсний шинжээч, МУИС-ийн багш, доктор, профессор

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Ж.Цогзолмаа, Үндэсний статистикийн хорооны Тооллого, өгөгдлийн шинжилгээний газрын Хүн ам, орон сууцны тооллогын хэлтсийн ахлах статистикч



АГУУЛГА

НЭГ. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.....	4
Ойлголт, тодорхойлолтууд	
ХОЁР. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ БА ХЭРЭГЛЭЭ.....	5
Нийгэм, жендэрийн бодлого	
ГУРАВ. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ АШИГЛАХ НЬ	6
Жендэрийн төлөв байдлын статистик	
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АШИГЛАХ	14
Сорилт ба боломжууд	
ТАВ. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ	15
ЗУРГАА. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ.....	22
ХАВСРАЛТ 1. ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ.....	24
МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ	29
ХҮСНЭГТ 1: ШАЛГУУР ШААРДЛАГУУДЫГ ХАНГАСАН БАЙДАЛ	30
ХҮСНЭГТ 2. ШАЛГУУР АСУУЛТУУД БА ХАРИУЛТ.....	31
ХАВСРАЛТ 1. ҮР ДҮН САЛБАРЫН ЯАМДААР	33



НЭГ. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТУУД

Жендэрийн статистик нь амьдралын бүхий л салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдлын ялгаа, тэгш бус байдлыг хангалттай тусгадаг (UNSD, 2016).

Жендэрийн статистикийг дараах шинж чанаруудын нийлбэрээр тодорхойлдог.¹ Үүнд:

- a) Мэдээлэл, тоон өгөгдлийг хүйсээр ангилан цуглуулж, үр дүнг танилцуулсан;
- b) Мэдээлэл, тоон өгөгдөл нь жендэрийн асуудлыг тусгасан;
- c) Мэдээлэл, тоон өгөгдөл нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн олон талт байдлыг хангалттай тусгаж, тэдний амьдралын бүхий л талыг хамарсан ойлголт, тодорхойлолтод үндэслэсэн;
- d) Мэдээлэл цуглуулах аргууд нь өгөгдөлд жендэрийн гажуудлыг өдөөж болох хэвшмэл ойлголт, нийгэм, соёлын хүчин зүйлсийг харгалзан үзсэн.

Жендэрийн статистик

Жендэрийн статистик нь хөгжлийн болон ядуурлыг бууруулах бодлогод жендэрийн чиг хандлагыг тусгахад чухал үүрэгтэй бөгөөд ядуурлын жендэрийн хэмжигдэхүүнүүдийн талаар илүү өргөн хүрээтэй ойлголтыг өгдөг. Иймд энэ нь эргээд бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг мэдэгдэхүйц өөрчлөх боломжийг олгодог (UNSD, 2016).

Хүйсээр ангилагдсан тоо баримт

Хүйсээр ангилагдсан тоо баримт гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээнд үндэслэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, бодлого, төлөвлөлтийн үр нөлөө эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн, ямар байдлаар нөлөөлж буйг нягтлан шинжлэх статистик үзүүлэлт юм.

Жендэрийн мэдрэмжтэй статистик

Жендэрийн мэдрэмжтэй статистик гэдэг нь тоо, мэдээ, мэдээллийг хүйсийн задаргаатай цуглуулахаас өргөн хүрээний үйл ажиллагаа бөгөөд хөгжлийн олон асуудлыг шийдвэрлэх хүрээнд жендэрийн ялгаатай байдлыг арилгах гол зэвсэг болдог. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бодит байдлыг гаргаж өгснөөрөө жендэрээс үүдэлтэй олон нийтийн буруу, хэвшмэл ойлголтыг эерэг болгоход тусалдаг. Мөн эмэгтэйчүүдийн

¹ UNSD (2016). Integrating a Gender Perspective into Statistics, Studies in Methods, Series F No. 111 Department of Economic and Social Affairs Statistics Division, United Nations, New York

аж байдлыг сайжруулахад чиглэсэн, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн зорилгод хүрэх үйл явцыг үнэлэх үнэн бодит, харьцуулагдахуйц мэдээллийн суурь болдог.

Иймд жендэрийн статистикийг явцуутгаар нь хэвшмэл сэтгэлгээ, төсөөллийг өөрчилж, тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого боловсруулах үйл явц гэж ойлгож болно. Харин өргөн утгаар нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдрал, жендэртэй холбоотой бодлогын үнэн зөв, бодит байдлыг тусган илэрхийлсэн статистикийг тодорхойлох, гаргах, нэгтгэн дүгнэх, тархаах үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, тоо мэдээллийг дан ганц хүйсээр ангилснаараа жендэрийн статистикийг бий болголоо гэж ойлгох бус түүнийг олон улсын болон үндэсний арга, аргачлал, стандартын дагуу зөв тодорхойлж, цуглуулах, боловсруулах, үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийх, хэрэглэгч, шийдвэр гаргагчдад хамгийн ойлгомжтой байдлаар хүргэх, тархаах үйл ажиллагааны цогц юм.

ХОЁР. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН АЧ ХОЛБОГДОЛ БА ХЭРЭГЛЭЭ

НИЙГЭМ, ЖЕНДЭРИЙН БОДЛОГО

Дэлхийн эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр бага хурал (Бээжин 1995) жендэрийн статистикийн хөгжлийн талаар чухал үр дүнд хүрснээр анх удаа олон улс үндэстэн жендэрийн статистикийг бий болгох, тархаах асуудлыг өргөн хүрээнд авч үзэх болов. Засгийн газрууд “хүйсээр ангилагдсан, төлөвлөлт, үнэлгээ хийх бололцоог хангасан мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах”-д онцгой ач холбогдол өгч, үйл ажиллагааг эрчимжүүлэх амлалтаа өгсөн². Улмаар засгийн газрууд болон бусад субъектээс бүх стратеги бодлого, хөтөлбөрийн хүрэн дэх үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ эмэгтэйчүүдийн асуудлыг тооцон үзэж, идэвхтэй, тодорхой зорилготой бодлого явуулах, ингэхдээ шийдвэр гаргахаасаа өмнө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд үзүүлэх үр дагаварт дүн шинжилгээ хийсэн байхыг шаардаж эхэлсэн юм.

Жендэрийн бодлого нь өөрчлөлтөд чиглэсэн давхар оролцооны илэрхийлэл болдог. Тухайлбал, нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн ялгаатай байдлыг харгалзан улс үндэстэн доторх болон гаднах үйл явцын эмэгтэй, эрэгтэй хүмүүст үзүүлэх нөлөөг илэрхийлдэг. Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал нь ялангуяа эмэгтэйчүүд, охид эсвэл өндөр настай эмэгтэйчүүдэд зориулагдсан үйлдлийг орлох бус харин тодорхой бодлогоор дамжуулан жендэрийн эрх тэгш байдлын нийтлэг ойлголтыг дэмжиж, тэгш байдлын давхар хэмжүүрийг бүрдүүлэхүйц тэгш байдлын бодлогыг агуулж байдаг (UNSD, 2016).

² НҮБ, 1996. Бээжингийн тунхаглал болон үйл ажиллагааг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Стратегийн зорилтууд, төлөвлөлт, үнэлгээнд зориулан хүйсээр ангилсан тоо баримт, мэдээлэл цуглуулж тараах



Жендэрийн статистик, түүнийг хэмжих шалгуур үзүүлэлт яагаад зайлшгүй шаардлагатай вэ?

- Жендэрийн статистик нь жендэрийн тэгш бус байдлын янз бүрийн илэрхийллийн цар хүрээ, эрч хүчийг харуулдаг хүчирхэг хэрэгсэл болдог.
- Жендэрийн статистикийг жендэрийн тэгш байдал, хүний үндсэн бүх эрх, эмэгтэйчүүд, охидын эрхийг бүрэн, тэгш хангахад чиглэсэн ахиц дэвшлийг хянахад ашигладаг.
- Жендэрийн статистик нь жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад бүх төрлийн нөөцөд хандах, ашиглахад чиглэсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, хянахад нотлох үндэслэл болдог.
- Жендэрийн статистик нь хүний үйл ажиллагааны тодорхой салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оруулсан хувь нэмрийн цар хүрээг харуулдаг.
- Жендэрийн статистик нь хөгжлийн болон ядуурлыг бууруулах бодлогод жендэрийн чиг хандлагыг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд илүү өргөн хүрээг хамардаг. Ядуурлын жендэрийн хэмжигдэхүүнүүдийн талаарх ойлголтыг энэ үзүүлэлтээр тод томруун харах боломжтой бөгөөд улмаар аливаа бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг эрс өөрчилж чаддаг.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах бодлого боловсруулах, хянахад жендэрийн статистик чухал үүргийг гүйцэтгэдэг.

ГУРАВ. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ АШИГЛАХ НЬ

ЖЕНДЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН СТАТИСТИК


Дээр дурьдсанчлан, жендэрийн статистик нь нийгэм, соёл, эдийн засаг, улс төр зэрэг бүхий л салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоо, хувь нэмрийг баримтжуулж, жендэрийн тэгш бус байдлын үндсэн шалтгаан, үр дагаврыг тусгахад ашиглагддаг. Иймд үндэсний статистикийн системээр дамжуулан жендэрийн холбогдох асуудлыг хөндсөн мэдээллийг тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийж, түгээх шаардлагатай. Бээжингийн үйл ажиллагааны тунхаглалын (НҮБ, 1996) 207(b)-д зөвлөсний дагуу албан ёсны статистикийн системээр жендэрийн асуудлыг тусгасан байдал, хүрэлцээг тогтмол хянаж байх ёстой. Мэдээлэл хэрэглэгчдийн тодорхойлсон жендэрийн асуудал нь одоо байгаа мэдээлэл цуглуулах хөтөлбөрт хамрагдаж, хэрэглэгчдэд нээлттэй байгаа эсэхийг тоймлон харуулахыг шаарддаг. Энэхүү тоймд үндэслэн жендэрийн үндсэн чиг хандлагын стратеги нь шинэ төрлийн мэдээлэл цуглуулж, зарим мэдээлэл цуглуулалтыг өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг илэрхийлдэг.

Жендэрийн тэгш байдлыг хангах стратеги нь мэдээлэл хэрэглэгч, мэдээлэл үйлдвэрлэгчдийн нягт хамтын ажиллагаа, үндэсний статистикийн байгууллага болон үндэсний статистикийн тогтолцооны дотоод уялдаа холбоо, үндэсний статистикийн байгууллага болон бусад яам, агентлаг хоорондын мэдээлэл солилцох гэрээнд суурилсан байх шаардлагатай.

Олон улсын практикт жендэрийн статистикийг хөгжүүлснээр дараах нийгэм, жендэрийн хөгжлийн зорилго, зорилтуудыг хангахад ашиглаж байна. Эдгээр нь:

Жендэрийн статистик нь бүх төрлийн нөөцийн хүртээмж дэх жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үндэслэл бүхий нотолгоог гаргаж тавьдаг.

ЗУРАГ 3.1 АЖИЛЛАГСАД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, ХҮЙСЭЭР, ХУВИАР, 2021 ОН³




Тэмдэглэл: Афганистан, Киргиз, Монгол, Пакистан, Түрк, Сингапур, Вьетнам улсуудыг сонгон оруулав.

³ Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага 2022. Цахим мэдээллийн сан. Ажиллагсад тоон мэдээлэл (<https://ilostat.ilo.org/data/#>)

Жендэрийн статистик нь жендэрийн тэгш бус байдлын илэрхийлэл, ялгаатай байдлын цар хүрээ, эрч хүчийг харуулдаг хүчирхэг хэрэгсэл болдог.

ЗУРАГ 3.2 АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТҮВШИН, АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР, ХҮЙСЭЭР, 2021 ОН⁴



Өөрчлөлтийг дэмжих зорилгоор тэдгээрт шаардлагатай арга хэмжээ авах боломжийг олгож, тэгш бус байдлын илрэлүүдэд нөлөөлж болохуйц янз бүрийн үндсэн шалтгааныг тодорхойлоход тусалдаг.


⁴ Дэлхийн банк 2022. Цахим мэдээллийн сан. Ажилгүйдлийн түвшин тоон мэдээлэл (<http://databank.world-bank.org>)

ЗУРАГ 3.3 ГЭР БУЛИЙН ШАЛТГААНЫ УЛМААР ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ГАДНА ҮЛДСЭН 15-64 НАСНЫ ХҮН АМ, ХҮЙСЭЭР, ЛАТИН АМЕРИК БОЛОН КАРИБЫН ТЭНГИСИЙН ОРНУУДААР⁵



Жендэрийн статистик нь нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бодит байдлыг ойлгоход тусалдаг.

ЗУРАГ 3.4 ЦАЛИН ХӨЛСГҮЙ ГЭРИЙН БОЛОН АСАРГААНЫ АЖИЛ, АЖЛЫН ХЭЛБЭР, ХҮЙС, ЛАТИН АМЕРИК БОЛОН КАРИБЫН ТЭНГИСИЙН ОРНУУДААР⁶




⁵ Латин Америк болон Карибын Тэнгисийн эдийн засгийн хороо (ECLAC), Өрхийн судалгааны мэдээллийн санд үндэслэв.

⁶ Латин Америк болон Карибын Тэнгисийн эдийн засгийн хороо (ECLAC), Өрхийн судалгааны мэдээллийн санд үндэслэв.




Жендэрийн статистик нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оруулсан хувь нэмрийг тодорхой харуулсан хүний үйл ажиллагааны талбаруудыг харуулдаг.

ЗУРАГ 3.5 (ТХЗ, ЗОРИЛТ-5.4.1) ГЭРИЙН БОЛОН АСРАН ХАЛАМЖЛАХ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ХӨДӨЛМӨРТ ЗАРЦУУЛСАН ЦАГ, 24 ЦАГТ ЭЗЛЭХ ХУВИАР, ХҮЙСЭЭР, АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР⁷



Жендэрийн статистик нь ядуурлыг бууруулахад жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бодлогын хэрэгсэл болдог.

ЗУРАГ 3.6 ЖЕНДЭРИЙН ТЭГШ БУС БАЙДЛЫН ИНДЕКС, 2018 ОН, АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР⁸




⁷ Дэлхийн банк. 2022. Цахим мэдээллийн сан, Гэрийн болон асран халамжлах үнэ төлбөргүй хөдөлмөрт зарцуулсан цаг тоон мэдээлэл. https://tcdata360.worldbank.org/indicators/949ba19f?country=BRA&indicator=28131&viz=line_chart&years=1980,2017),

⁸ НҮБ. 2022. Цахим мэдээллийн сан, Жендэрийн тэгш бус байдлын индекс (<https://data.un.org/Default.aspx>),

Жендэрийн статистик мэдээллийг олон нийтэд түгээх нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулахад маш чухал нөлөөтэй. Түүнчлэн, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, нийгэмд оруулах хувь нэмрийг зөвөөр тайлбарлах гэр бүл, ажлын байран дахь үүргийн хуваарилалтад жендэрийн шинэ тэнцвэрийг бий болгох шийдвэр гаргах байр суурийг илэрхийлдэг.

ЗУРАГ 3.7 15-24 НАСНЫ ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН СТАТУС, АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР, ХҮЙСЭЭР⁹




Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах бодлого боловсруулах, хянахад жендэрийн статистик чухал үүрэг гүйцэтгэдэг.

⁹ Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн байгууллага. 2022. 15-24 насны залуучуудын ажилгүйдлийн түвшин тоон мэдээлэл цахим мэдээллийн сан (<https://ilostat.ilo.org/data/#>)




ЗУРАГ 3.8 ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АМЬ НАСАНД ХҮРСЭН БАЙДАЛ, 100,000 ЭМЭГТЭЙД НОГДОХ, АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР¹⁰



Жендэрийн статистик нь эдийн засаг, олон нийтийн амьдрал болон улс төрийн шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хянах боломжийг олгодог.

ЗУРАГ 3.9 УДИРДАХ АЛБАН ТУШААЛД АЖИЛЛАДАГ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, (ТХЗ-5.5.2) АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР¹¹




¹⁰ Дэлхийн банк. 2022. Цахим мэдээллийн сан (<http://databank.worldbank.org>), Эмэгтэйчүүдийн амь насанд хүрсэн байдал тоон мэдээлэл

¹¹ Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн байгууллага. 2022. Цахим мэдээллийн сан (<https://ilostat.ilo.org/data/#>), Удирдах албан тушаалд ажилладаг эмэгтэйчүүдийн эзлэх хувь тоон мэдээлэл

Эмэгтэйчүүдийн бүрэн, үр дүнтэй оролцоог хангах, бүх түвшинд манлайлах тэгш боломжийг бий болгохын тулд улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд шийдвэр гаргахад жендэрийн статистикийг ашигладаг.

ЗУРАГ 3.10 ПАРЛАМЕНТИЙН ГИШҮҮДЭД ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ (ТХЗ-5.5.1), АЗИЙН СОНГОСОН УЛСУУДААР, 2021 ОН¹²



¹² Дэлхийн банк. 2022. Цахим мэдээллийн сан. Парламентийн гишүүдэд эмэгтэй гишүүдийн эзлэх хувь тоон мэдээлэл (<http://databank.worldbank.org>)



ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ ХӨГЖҮҮЛЖ, АШИГЛАХ

Байгууллагын бодлогод жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгахдаа эн тэргүүнд жендэрийн талаас анхаарвал зохих ямар асуудлыг шийдэх ёстой гэдгээ тодорхойлох шаардлагатай. Ямар асуудлыг шийдэх шаардлагатайг үндэслэх, тухайн асуудлыг шийдэхэд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг тодруулахдаа хүйсээр ангилсан тоон мэдээ, баримт, мэдээлэлд суурилсан жендэрийн дүн шинжилгээнд тулгуурлана. Ялангуяа жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалд тулгуурлан асуудлыг тодорхойлоход хүйсээр ангилсан мэдээ, баримт, нотолгоо чухал үүрэгтэй. Иймд байгууллага нь удирдлага, менежментийн тогтолцоондоо хүйсээр ангилсан мэдээллийг өргөн хүрээнд цуглуулж, мэдээллийн сан үүсгэн, түүнийгээ шинжилдэг, ашигладаг байх шаардлагатай.

Шигтгээ 1. Байгууллагын бодлогод жендэрийн статистик, дүн шинжилгээг ашиглах

Байгууллагын нэгж, хэлтэс, ажилтнууд хамтдаа нөхцөл байдлын үнэлгээ хийн, хүйсээр ангилсан тоо мэдээ, мэдээлэл, нотолгоонд үндэслэн асуудлаа тогтоосны дараа байгууллагын хэмжээнд хамаарах асуудал мөн эсхийг тодорхойлно. Жишээ нь, эрдэс баялгийн салбарын байгууллагуудад эмэгтэй ажилтнууд харьцангуй богино хугацаанд ажиллаж, чадамж сайтай ажилтнууд ажлаас гарах, шилжих хөдөлгөөн их байна гэсэн асуудал дэвшигджээ. Энэхүү асуудлыг нарийвчлан тодорхойлоход дараах мэдээлэл шаардлагатай болно. Үүнд:

- *Эрэгтэй, эмэгтэй ажилтнуудын цалин хөлсний зөрүү, түүний шалтгаан*
- *Гэрлэсэн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувийн жин*
- *Бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувийн жин*
- *Чөлөө авсан, ажил тасалсан эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хувийн жин, шалтгаан хүйсээр г.м.*

Эдгээр мэдээлэл танай байгууллагад бэлэн бий юу? Үгүй тохиолдолд зориудаар эдгээр мэдээллийг цуглуулах шаардлага бий болж байна. Асуудлын мод зураглах аргыг ашиглаж болно. Жишээ нь модны их бие нь тухайн тулгамдсан асуудлыг илэрхийлнэ. Модны мөчир нь тухайн тулгамдсан асуудлаас шалтгаалж үүссэн сөрөг үр дагаврыг илэрхийлнэ. Модны үндэс нь тухайн тулгамдсан асуудлыг үүсгэгч суурь шалтгааныг илэрхийлнэ. Нар, ус, хөрс нь нөлөөлөгч хүчин зүйлсийг илэрхийлнэ. Ийнхүү оролцогч талууд хамтдаа нөхцөл байдлын үнэлгээ хийж, хүйсээр ангилсан мэдээлэл, нотолгоонд үндэслэн асуудлаа тогтоосны дараа энэ нь жендэрт хамаарах асуудал мөн эсхийг тодорхойлно.

Эх сурвалж: Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо, 2020.

СОРИЛТ БА БОЛОМЖУУД

Жендэрийн статистикийг бий болгоход дараах боломжуудыг бүрдүүлж, ашигласнаар тулгарч болох сорилтуудыг даван туулж чадна.

Жендэрийн статистикийг бий болгох алхамууд:

- Мэдээлэл цуглуулах хэрэгслийг сайжруулах;



- Мэдээллийг хүйсээр ангилан цуглуулж, үр дүнг танилцуулах;
- Мэдээлэл нь жендэрийн асуудлыг тусгасан байх;
- Мэдээллийг харьцуулах, ялгаатай байдлыг илрүүлэх дүн шинжилгээний арга зүй ашиглах;
- Үзэл баримтлал, тодорхойлолтын талаар тохиролцох;
- Жендэрийн онцлогтой судалгааг үе үе төсөвлөсөн байдлаар зохион байгуулах, жишээ нь цаг ашиглалтын судалгаа, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн судалгаа гэх мэт;
- Мэдээллийн чанарт ач холбогдол өгч мэдээллийн боломжит бүхий л эх сурвалжуудыг /тоон болон чанарын/ бүрэн дүүрэн ашиглах;
- Мэдээллийн нууцлал, найдвартай байдлыг хангах;
- Хэрэгжилтийг удирдан чиглүүлэх мэдээллийн хэрэглээг дэмжих /жендэрийн асуудал хариуцсан ажлын хэсэг, мэргэжилтэнтэй болох, жендэрийн статистикийн бага хурал зохион байгуулах гэх мэт/.

ТАВ. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ

Жендэрийн статистикийг гаргах үйл явц нь бусад статистикийн нэгэн адил харилцан уялдаа бүхий олон төрлийн үйл ажиллагааг хамардаг. Эдгээр үйл ажиллагаа бүр, тэдгээрийн уялдаа холбоо нь эцсийн бүтээгдэхүүний чанарт ихээхэн нөлөөлдөг. Иймд бүх үйл ажиллагааг үр дүнтэй, зөрчил, саадгүй, нягт уялдуулсан нэгдсэн багцыг бүрдүүлэхийн тулд жендэрийн статистик бий болгох үйл явцыг эхнээс нь төгсгөл хүртэл цогцоор нь харах явдал нэн чухал юм. Өөрөөр хэлбэл, маш сайн нарийн тодорхойлсон зорилтууд, тэдгээрийг зөв үнэлэх хэмжигдэхүүнийг тогтоох хэрэгтэй.

Үндэсний статистикийн тогтолцооны хүрээнд жендэрийн статистикийг гаргахад дараах 4 мэдээллийн эх үүсвэрийг өргөн ашиглаж байна. Эдгээр нь:

- Хүн амын тооллого: Засаг захиргааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх зэрэгт ашиглах зорилгоор улсаас 10 жил тутамд нийт орон даяар нэгэн зэрэг явагддаг хүн амын судалгаа.
- Хүн амын түүвэр судалгаа: Эх олонлогоос тухайн сэдэвчилсэн судалгаанд хамруулахаар сонгосон тодорхой нэгжүүдийн бүлгийн дунд хийгдэж буй хүн амын судалгаа. Олон сэдвийн хүрээнд хийгдэж буй хүн амын түүвэр судалгаануудаас “Цаг ашиглалтын судалгаа” нь жендэрийн олон чухал асуудлыг шинжлэхэд маш их мэдээлэл өгдөг.
- Бизнесийн судалгаа: Удирдлага буюу менежерүүдэд хамгийн оновчтой шийдвэр гаргахад туслах зорилгоор, ажлын талбарт бий болсон ямар нэг тулгамдсан



бэрхшээлтэй, шийдэл шаардаж буй онцгой асуудлыг судлах, шийдэх арга замыг тодорхойлох цогц үйл ажиллагаа.

- Захиргааны бүртгэл: Үндэсний түвшинд хийгддэг иргэний бүртгэл мэдээллээс гадна тухайн байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хийгдэж буй ажиллагсдын бүртгэл.

Жендэрийн статистикийг гаргахад мэдээллийг хүйсээр ангилахаас гадна дараах дөрвөн элементийг онцгойлон анхаарах шаардлагатай. Эдгээр нь:

Нэгдүгээрт, статистик нь нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдтэй холбоотой асуудал, асуултуудыг тусгасан байна. Үүний тулд дараах хоёр аргыг ашиглаж болно.

- а) эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд ижил боломж, статусыг эдлэж чадахгүй байх (хөдөлмөрийн зах зээл, мэргэжлийн боловсрол, үр чадвараа хөгжүүлэх г.м) эсвэл эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдралд өөр өөр хэлбэрээр нөлөөлж болзошгүй зарим асуудалд анхаарлаа хандуулах (гэр бүлийн хүчирхийлэл, үйлдвэрлэлийн осол);
- б) жендэрийн тэгш бус байдал үүсэх магадлалтай буюу хүн амын бүлгүүд дотор илүү эрсдэл өндөр эмзэг тодорхой бүлгийг харгалзан үзэх (бага насны хүүхэдтэй залуу эмэгтэйчүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ганц бие аавууд, хөгжлийн бэрхшээлтэй ажилчид).

Хоёрдугаарт, сонгож ашигласан ойлголт, тодорхойлолт, хэмжүүр нь нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн байр суурь, жендэрийн үүрэг, харилцааг зохих ёсоор тусгах боломжтой байна.

Гуравдугаарт, мэдээлэл цуглуулах хэрэгслийг сонгохдоо мэдээлэлд жендэрийн гажуудлыг бий болгож болзошгүй хэвшмэл ойлголт, нийгэм, соёлын хүчин зүйлийг харгалзан үзсэн байна.

Дөрөвдүгээрт, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, танилцуулга хийхдээ эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хоорондын ялгаа, ижил төстэй байдлыг харуулсан байна.



Шигтгээ 2. Мэргэжил сонголт дахь жендэрийн тэгш бус байдлыг илрүүлэх

Эмэгтэй, эрэгтэй суралцагчид уламжлалт мэргэжлийн хөтөлбөрүүдийг сонгон суралцаж байгааг өөрчлөх эсэх тухай бодлогын асуудлыг нарийвчлан тодорхойлоход дараах мэдээлэл шаардлагатай болно. Үүнд:

- Мэргэжлийн хөтөлбөрүүд, тэдгээрт суралцагчдын хүйсийн харьцаа, хувийн жин
- Төгсөгч эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувийн жин
- Тэтгэлгээр суралцагчдын хүйсийн харьцаа
- Чөлөө авсан, сургуулиас гарсан, хөтөлбөрөө сольсон оюутнуудын хувийн жин, шалтгаан, хүйсээр г.м

Үндэсний хэмжээний хүйсээр ангилсан тоон мэдээллийг ҮСХ-ны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn; салбарын статистикийн мэдээллийг БСШУЯ-ны <http://www.meds.gov.mn/Statistic>, мэдээллийн сангаас сургуулийн хэмжээний мэдээллийг их, дээд сургуулийн цахим хуудас, тухайн сургуулийн хөтөлбөрийн болон оюутны албаас авах боломжтой. Мөн БСШУЯ-ны боловсролын салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл (хичээлийн жилээр) хэвлэгдэн гардаг бөгөөд цахим хуудсан дахь хүйсээр ангилсан дэлгэрэнгүй мэдээллийг ашиглаж болно. Цаашлаад өмнө хийгдсэн суурь болон бодлогын судалгааны тайлан, нэг сэдэвт бүтээлүүдээс зохих мэдээллийг авч болно. Гэхдээ хүйсээр ангилсан тоо, мэдээллийн цуглуулалт, бүрдүүлэлт хангалттай биш байх нь жендэрийн дүн шинжилгээний хүрээг хязгаарлах гол асуудал болдог.

Эх сурвалж: БСШУЯ, АХБ, 2017

Жендэрийн статистикийг бий болгох үйл явц нь өргөн утгаараа статистикийн бусад салбарынхтай төстэй бөгөөд дараах үндсэн алхмуудаар хийгдэнэ. Тухайлбал:

- Судлах шаардлагатай сэдвүүдийг сонгох;
- Амьдралын янз бүрийн салбарт жендэрийн ялгаа, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хувь нэмрийг ойлгоход шаардлагатай баримт, тоон өгөгдлийг тодорхойлох;
- Нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн олон янз байдлыг зохих ёсоор тусгасан шинэ үзэл баримтлал, тодорхойлолт, аргачлалыг шаардлагатай бол боловсруулах;
- Мэдээлэл цуглуулах арга, загварыг сонгох: мэдээлэл цуглуулах нэгжийг сонгох; түүврийн хэмжээг тодорхойлох, асуулгын хуудас, ярилцлагын удирдамж гэх мэт судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулан түрших; асуулга авагчдыг сургаж бэлтгэх;
- Статистик мэдээг ашиглахад хялбар хэлбэрээр дүн шинжилгээ хийх, танилцуулах; статистикаар гарч ирсэн үр дүнг бодлого боловсруулагчид, төлөвлөгчдөөс гадна өргөн хүрээний хэрэглэгчдэд түгээх.

ХҮСНЭГТ 1. ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ 1. БАЙГУУЛЛАГА ДАХЬ ХҮЙСЭЭР
АНГИЛСАН МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭ¹³

Мэдээллийн хүрээ	Дүн шинжилгээ	Үр дүнгийн ашиглалт
Ажиллагсдын тоо, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдад эрэгтэй, эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь - Хүйсийн харьцаа: 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо 	ААНБ-д хүйсийн тэнцвэртэй байдал хангагдсан эсэхийг илрүүлнэ. Үүнийг ажил мэргэжил, нэгж, албаар задлан гаргаж болно.
Удирдах ажилтны тоо, хүйсээр (үүнийг түвшин, нэгжээр ялган цуглуулж болно)	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: нийт удирдах албан тушаалд /менежрүүдийг оруулаад/ эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 	Удирдлага дахь хүйсийн тэнцвэртэй байдал хангагдсан эсэхийг илрүүлнэ. Үүнийг зөвлөл, албан тушаалаар задлан гаргаж болно.
Илүү, уртасгасан цагаар болон гэрээгээр ажиллагсдын тоо, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Илүү, уртасгасан цагаар болон гэрээгээр ажиллагсдад эрэгтэй, эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь 	Ажил-гэрийн тэнцвэрийг хангах хүрээнд асуудлыг нягтлахад ашиглана. Бага насны (0-12) хүүхэдтэй эсэхээр хүйсээр ангилан шинжилж болно.
Гэрээгээр ажиллаж буй хугацаа, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Гэрээт ажлын дундаж хугацааг эрэгтэй, эмэгтэй ажиллагсдаар ангилан тооцно. 	Ажил-гэрийн тэнцвэрийг хангах хүрээнд асуудлыг нягтлахдаа ашиглана.
Ажлын дундаж цаг, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Өдрийн эсвэл долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэх дундаж хугацааг эрэгтэй, эмэгтэй ажиллагсдаар ангилан тооцно. 	Хөдөлмөрийн хуулийг мөрдөж буй байдал, илүү цагийн хөлс төлөлтийг илрүүлэхэд ашиглана.
Дундаж цалин хөлсний хэмжээ, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Дундаж цалин хөлсний хэмжээг хүйсээр ангилан тооцно. Медиан/ голчийг ашиглаж болно. - Албан тушаал, ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр задалж харах хэрэгтэй. 	Цалин, шагнал, урамшуулал, дэмжлэг, албан тушаал ахих дэвших боломж эрэгтэй, эмэгтэйчүүдэд хэр шударгаар хуваарилагдаж буйг илэрхийлнэ.

¹³ Мэдээллийг дахин сайжруулж энд ашигласан болно. Эх сурвалж: Эрдэс баялгийн салбарын Жендэрийн сургалтын гарын авлага, хуудас 43-44. Монгол улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төсөл, СЕСМИМ төсөл, Улаанбаатар хот



Мэдээллийн хүрээ	Дүн шинжилгээ	Үр дүнгийн ашиглалт
<p>Урамшууллын дундаж хэмжээ, төрлөөр, хүйсээр</p>	<ul style="list-style-type: none"> - Урамшууллын дунджийг хүйсээр ангилан тооцно. Медиан/голчийг ашиглаж болно. Олгогдсон урамшуулын хэлбэр, төрөл, хэмжээг мөн хүйсээр задалж харах хэрэгтэй. - Албан тушаал, ажил мэргэжлийн ангиллаар, хүйсээр задалж харах хэрэгтэй. 	
<p>Шагнуулсан ажиллагсдын тоо, хүйсээр</p>	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт эрэгтэй эсвэл эмэгтэй ажиллагсдад шагнуулсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь - Албан тушаал, ажил мэргэжлийн ангиллаар задалж харах хэрэгтэй. 	
<p>Тусламж дэмжлэг авсан ажиллагсдын тоо, хүйсээр</p>	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт эрэгтэй эсвэл эмэгтэй ажиллагсдаас тусламж, дэмжлэг авсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, - Авсан тусламж дэмжлэгийн хэлбэр болон үнийн дүн, хүйсээр 	
<p>Ажил мэргэжил, албан тушаал, мэргэжлийн зэргээ өөрчилсөн ажиллагсдын тоо, хүйсээр</p>	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт эрэгтэй эсвэл эмэгтэй ажиллагсдаас ажил, мэргэжил, албан тушаалаа өөрчилсөн эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь - Энгийн ажлаас мэргэжлийн ажилд шилжигсэд, хүйсээр - Албан тушаалын зэргээ ахиулагсад, хүйсээр - Мэргэжлийн зэргээ ахиулсан ажиллагсад хүйсээр 	
<p>Ажиллагсдын ажилд орох гарах хөдөлгөөн, хүйсээр</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлаас гарсан нийт ажиллагсдад эрэгтэй, эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь - Шалтгаан, хүйсээр 	<p>Ажиллагсдын тогтвор суурьшил, ажилд орох, ажлаас гарах хөдөлгөөн, шалтгааныг илрүүлэхэд ашиглана.</p>



Мэдээллийн хүрээ	Дүн шинжилгээ	Үр дүнгийн ашиглалт
Бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтийн боловсруулалтад оролцогчдын тоо, хүйсээр, албан тушаалын зэрэглэлээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдад бодлого, үйл ажиллагааны төлөвлөлтөд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь - Уг үйл ажиллагаанд оролцогсдын албан тушаалын зэрэглэл, хүйсээр 	Бодлого, шийдвэрт оролцогчдын хүйсийн ялгааг тодруулахад ашиглана. Ажиллагсдын дуу хоолойг хэр өргөн цар хүрээнд авч үзэж буйг илэрхийлнэ.
Төсөв боловсруулахад оролцсон ажиллагсдын тоо, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдад төсөв боловсруулахад оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь - Уг үйл ажиллагаанд оролцогчид албан тушаалын ангилал, хүйсээр 	
Төсөв хуваарилах шийдвэр гаргагчдын тоо, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдаас төсөв хуваарилах шийдвэр гаргалтанд оролцсон эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь - Шийдвэр гаргагчдын хүйсийн харьцаа 	
Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдагсдын тоо, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдад мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь - Сургалтад хамрагдсан дундаж хугацаа, хүйсээр, - Гадаад, дотоод сургалтуудад хамрагдагсад хүйсээр 	Ур чадвараа дээшлүүлэх боломжийн ялгааг харахад ашиглана. Хүний нөөцийн хөгжлийн стратеги, төсөвлөлт хэр жендэрийн мэдрэмжтэй байгаа илэрхийлнэ.
Эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөөнд хамрагдсан ажиллагсдын тоо	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдад эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөөнд хамрагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 	
Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдагсдын тоо, хүйсээр	<ul style="list-style-type: none"> - Хувийн жин: Нийт ажиллагсдад эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь 	Эрүүл мэндийн зөвлөгөө, тусламж, сургалтад хамрагдагсдын ялгааг харахад ашиглана.



Мэдээллийн хүрээ	Дүн шинжилгээ	Үр дүнгийн ашиглалт
Ар гэрийн шалтгаанаар чөлөө авсан ажиллагсдын тоо, хүйсээр	- Хувийн жин: Нийт ажиллагсдаас ар гэрийн шалтгаанаар чөлөө авсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь	Ажил-гэрийн тэнцвэрийг нягтлахад ашиглана.
Шалтгаангүйгээр ажил тасалсан ажиллагсдын тоо, хүйсээр	- Хувийн жин: Нийт ажиллагсдаас шалтгаангүйгээр ажил тасалсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн эзлэх хувь, насны бүлэг хүйсээр задалж болно.	Хөдөлмөрийн сахилга бат дахь ялгааг тодруулахад ашиглана.
Ариун цэврийн өрөөний суултуурын тоо, хүйсээр	- Харьцаа: Нийт эрэгтэй эсвэл эмэгтэй суултуурт ногдож буй эрэгтэй, эмэгтэй ажиллагсдын тоо	
Ажлын хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүртээмж, хүйсээр	- Хувийн жин: Ажлын хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувь	Жендэрийн нийцэмжтэй ажлын байрны орчин хэр бүрдсэн болохыг илэрхийлнэ.
Эрэгтэй, эмэгтэй ажиллагсдад бие засах газар, амрах өрөө, хувцас солих өрөө тусдаа байдаг эсэх	- Оффис, үйлдвэрлэл, үйлчилгээ, туслах болон үйлчилгээний ажилчдаар задалж харах	Ажлын талбар, хэлтэс, тасгаар (уурхай, үйлдвэр, оффис г.м)-аар ялган тооцоолж болно.
Ажлын байр, оффисын өрөөний хуваарилалт, нэг хүнд ногдох зай, хүйсээр	- Оффисын өрөөний зайны дунджийг хүйсээр ангилан тооцно. - Үйлчилгээ, үйлдвэрлэл, туслах болон үйлчилгээний ажилчдаар задалж харах	
Ажиллагсдаас ирүүлсэн санал, гомдол, төрөл, хүйсээр Гомдол барагдуулсан байдал, хүйсээр	- Ирсэн санал гомдлын тоо, төрөл, гомдол гаргагчийн хүйсээр - Шийдвэрлэсэн асуудлын тоо, төрөл, гомдол гаргагчийн хүйсээр	Ажлын байран дахь жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх, гомдол барагдуулах механизмыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглана.

Байгууллагын түвшин дэх хүйсээр ангилсан дараах мэдээллийг тодорхой цаг хугацааны хүрээнд (улирал, хагас жил эсвэл жил г.м) тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийж, үр дүнг ил тод мэдээлж байх шаардлагатай.

Хүйсээр ангилсан тоон болон чанарын мэдээллийг цуглуулсны дараагаар дүн шинжилгээ хийж, зохих ялгаа илэрсэн бол ямар шалтгаантай болох, ямар үр дагавар гарч болохыг нягталж, холбогдох өөрчлөлтийг төлөвлөнө.



ЗУРГАА. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

Үндэсний статистикийн бүх систем хүйсээр ангилсан статистик үзүүлэлтийг гаргахыг зорьж байна. Гэсэн хэдий ч гаргаж авсан бүх мэдээлэл нь тухайн нийгэм дэх жендэрийн асуудлыг тусгах, дүн шинжилгээ хийхэд хангалтгүй, мөн тэдгээрийг түгээх, тайлбарлахдаа жендэрийн ялгаа, түүний шалтгааныг онцолж чадахгүй байх явдал элбэг тохиолдож байна. Цаашилбал, тухайн улс орны бодлого боловсруулагчид эсвэл төлөвлөгчдийн хувьд чухал гэж үздэг жендэрийн зарим асуудлыг үндэсний статистикийн системээс гаргаж буй мэдээллээс гаргах боломжгүй байна.

Иймд, үндэсний хэмжээнд тодорхойлсон жендэрийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай статистик мэдээ болон үндэсний статистикийн тогтолцооноос шалтгаалан одоогийн байдлаар гаргаж буй статистикийн хоорондын зөрүүг тодорхойлж, жендэрийн статистикийг сайжруулах үндэслэл болгож болно. Харгалзан үзэх шаардлагатай жендэрийн асуудал, тэдгээрийг шийдвэрлэхэд хэрэгтэй байгаа жендэрийн статистикийн талаар тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь өнөөгийн бодлогын зорилго, төлөвлөгөө, хэмжилтийн аргачлалаас мөн хамаарч байна.

Анхаарал хандуулах шаардлагатай жендэрийн нийтлэг асуудлын хувьд дэлхийн болон бүс нутгийн түвшинд загваруудыг гаргаж өгдөг. Тухайлбал, Бээжингийн үйл ажиллагааны тунхаглал нь ядуурал, боловсрол, сургалт, эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөн, эдийн засаг, эрх мэдэл, шийдвэр гаргах түвшин, окид, эмэгтэйчүүдийн эрх, хэвлэл мэдээлэл, байгаль орчин зэрэг санаа зовоосон хэд хэдэн чухал салбарыг тодорхойлсон. Бүс нутгийн түвшинд ч мөн жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Мөн НҮБ-ээс тогтвортой хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн жендэрийн чанарын үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, удирдамжуудыг боловсруулан, улс үндэстний түвшин тооцоолох үндэсний чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг авч байна.

Тухай улс үндэсний түвшинд жендэрийн асуудлаар тэргүүлэх чиглэлийг статистикчид болон статистикийн гол хэрэглэгчидтэй зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулж тодорхой болгох нь нэн чухал юм. Тухайн асуудалд илүү гүнзгий дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ анхаарч үзэх шаардлагатай жендэрийн асуудлаарх үндэсний тэргүүлэх чиглэлүүд нь тухайн улс оронд шаардлагатай байгаа жендэрийн статистикийн үзүүлэлтийн үндэс болдог. Учир нь асуудлын шалтгаан, үр дагавар нь статистикийн сонголт, мэдээлэл цуглуулах аргуудад нөлөөлөх тул нэн тэргүүний зорилтуудын нэг болох эсэхийг шийдэх нь чухал юм.

Жендэрийн дүн шинжилгээгээр илрүүлсэн үр дүн, үнэлгээ нь үндэсний статистикийн газраас гаргасан тогтмол болон жендэрт чиглэсэн үр дүнгийн хүснэгт, мэдээллийн танилцуулга, түгээлттэй танилцах замаар цуглуулсан мэдээллийг боловсруулж, холбогдох шинж чанараар нь ангилж, түгээх боломжтой эсэхийг тодорхойлох ёстой.



Мэдээллийн одоо байгаа эх сурвалж, түгээх бүтээгдэхүүний үнэлгээний үндсэн дээр статистикчид шаардлагатай жендэрийн статистикийн эхний үе шатанд мэдээллийн зөрүүг тодорхойлж, (а) одоо байгаа өгөгдлийг илүү сайн ашиглах эсвэл дахин боловсруулах шаардлагатай эсэхийг шийдэх боломжтой. Дэд өгөгдлийг дахин кодлох, дахин тоолох эсвэл дахин дүн шинжилгээ хийх; (б) одоо байгаа мэдээлэл цуглуулах аргачлалыг сайжруулах; (в) цоо шинэ хэрэглэгдэхүүн эсвэл одоо байгаа хэрэглэгдэхүүнд нэмэлт мэдээлэл оруулж цуглуулах шаардлагатай. Үлгэрчилсэн жишээ болгон Тогтвортой хөгжлийн жендэрийн зорилтуудыг хэмжих чанарын үзүүлэлтийг хэрхэн тооцох нэг аргачлалыг "ТА 9542-МОН "Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийхэд мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглах нь" ҮСХ-ноос АХБ-тай хамтран хэрэгжүүлсэн төслөөс гаргасан үр дүнгээр Хавсралт 1-д үзүүлэв.



ХАВСРАЛТ 1. ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ

Тогтвортой хөгжлийн үзүүлэлт 5.с.1: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд төсөв хуваарилдаг, хянах тогтолцоотой эсэх

ТА 9542-МОН “Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийхэд мэдээллийн олон эх үүсвэрийг ашиглах нь” төслөөс гаргасан үр дүнг ашиглав.

Ойлголт: Үзүүлэлт 5.с.1 нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад зориулж хуваарилсан төсвийн зарцуулалтыг хянах, түүнийг олон нийтэд нээлттэй болгох ажлыг үнэлэх зорилготой. Энэ үзүүлэлт нь санхүүгийн тогтолцооны шинж байдлыг илэрхийлнэ. Харин жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх/чадавхжуулахад (ЖЭТБЭЭМ) хуваарилсан төсвийн тоо хэмжээ, чанарын үзүүлэлт биш. Үзүүлэлт нь дараах гурван шалгуурыг хэмжинэ.

- а) ЖЭТБЭЭМ-д засгийн газраас анхаарч нөөцийг бодлого, хөтөлбөрүүдэд илүү хуваарилахад анхаарах.
- б) Засгийн газар төрийн санхүүгийн удирдлага, менежментийн циклээр дамжуулан ЖЭТБЭЭМ-д зориулж нөөцийг төлөвлөж, төсөвлөдөг бол үнэлэх.
- в) Засгийн газар ЖЭТБЭЭМ-д зориулж төсвийг хуваарилдаг бол түүнийг олон нийтэд ил тод болгоход анхаарах.

Энэ үзүүлэлт нь засгийн газар жендэрийн эрх, тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай төсвийг бүрдүүлж, хуваарилах тогтолцоог хөгжүүлэх, энэ талаар олон нийтэд мэдээлдэг болгох зорилготой. Уг тогтолцоог Сангийн яам бусад яамд, Жендэрийн Үндэсний Хороотой хамтран удирдах ба УИХ эсвэл төрийн аудит хянана.

Ойлголтын тайлбар

Шалгуур 1-т:

“Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд нь жендэрийн эрх тэгш, сайн сайхан байдлыг хангах зорилтод анхаарч боловсруулагдсан” гэж тодорхойлж болно.

- Бодлого, хөтөлбөр зөвхөн эмэгтэйчүүд, охидод тусгайлан чиглэсэн. Жишээ нь: засгийн газрын хөтөлбөр нь зөвхөн сургуулийн эмэгтэй сурагчид, эсвэл эцэг эхийн халамжийн хөтөлбөр, эсвэл Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө; эсвэл
- Бодлого, хөтөлбөр эмэгтэйчүүд, охид эсвэл эрэгтэй, хөвгүүдэд аль алинд чиглэсэн, жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдал анхдагч зорилго нь болсон. Жишээ нь, жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг олон нийтэд зориулсан мэдээлэл түгээх, жендэрийн эрх тэгш байдлын тухай ажлын байран дээрх сургалтын хөтөлбөрүүд; эсвэл

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь бодлого, хөтөлбөрийн үндсэн зорилго биш, харин хөтөлбөр нь жендэрийн ялгааг бууруулах арга хэмжээг багтаасан. Эдгээр хөтөлбөрүүдэд дэд бүтэц, төрийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал зэрэг багтана. Жишээ нь, дэд бүтцийн хөтөлбөрт эмэгтэй ажиллах хүчинг оролцуулах, эсвэл нийтийн тээврийн хөтөлбөрийг боловсруулахад эмэгтэйчүүдийн хэрэгцээг загварт тусгаж өгөх гэх мэт.

“Бодлого, хөтөлбөрүүдэд төсөв хангалттай хуваарилагдсан, ерөнхий зорилгууд болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилго аль алиныг хангасан” гэж тодорхойлж болно.

- Бодлого, хөтөлбөрүүд нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгод анхаарч боловсруулагдсан, зорилгуудад шаардлагатай төсөв хангалттай хуваарилагдсан, санхүүгийн эх үүсвэр нэмэлт эх үүсвэрээс бус төсвийн хуваарилалтаар хангагдсан.

“Хуваарилагдсан төсвийн дагуу нөөцийг зарцуулж, гүйцэтгэсэн” гэж тодорхойлж болно.

- Хууль, тогтоомжид жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгыг сайн тусгаж, эдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг төсөвт тусган, шаардлагын дагуу төсвийг зарцуулан гүйцэтгэсэн, хэрвээ төсвийн зарцуулалтад хэлбэлзэл гарсан бол засийн газрын байгууллагуудад (Жишээ нь, Сангийн яам, УИХ, аудитын байгууллага, бусад холбогдох байгууллага) батлагдсан төсвийн гүйцэтгэлийн зөрүү гарсан шалтгааныг нотолгоотой тайлбарласан байна.

Шалгуур 2-т:

“Төсвийн мэдэгдэл” гэж тодорхойлж болно

- Тайлант жил бүрийн эхэнд төрийн байгууллагууд Сангийн яаманд төсвийн мэдэгдэл хүргүүлсэн байна. Уг мэдэгдэлд ирж буй жилд төрийн байгууллагууд үнийн санал, төсвийн хуваарилалт, хэрэгцээгээ тусгасан байна. Энд байгууллага бүрийн ирэх жилд шаардлагатай төсвийн хамгийн дээд хэмжээ мэдээлэгдсэн байна.

“Гол бодлого, хөтөлбөрүүд” гэж тодорхойлж болно.

- Засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгыг сайн тодорхойлоход анхаарч боловсруулагдсан (1-р шалгуурт тодорхойлогдсоноор).

“Жендэрийн урьдчилсан нөлөөллийн үнэлгээ” - гэж тодорхойлж болно.

- Төсөвт нөөцийн хуваарилалт хийхдээ ялангуяа жендэрийн эрх тэгш байдлын нөлөөллийг урьдчилан тооцож үнэлсэн байна. Жишээ нь, төсөвт суулгахаас өмнө бэлэн мөнгө шилжүүлэх нөхцөлт хөтөлбөр нь охидын сургуульд хамрагдалтанд хэрхэн нөлөөлөхийг тооцно.

“Хүйсээр ангилагдсан статистик, тоо мэдээлэл бүх гол бодлого, хөтөлбөрүүдэд системтэй тусгагдсан” гэж тодорхойлж болно.



- Хүйсээр ангилагдсан тоо мэдээллийн багц, статистик тогтмол бэлэн байгаа, жендэрийн эрх тэгш байдлын зөрүү, бодлогын хөрөнгө оруулалтын загвар, нөлөөллийн үнэлгээ хийх нотолгоо бүхий суурь бааз бий болсон.

“Жендэрийн төсвийн тайлан” гэж тодорхойлж болно.

- Баримт бичиг энэ нь жендэртэй холбоотой зорилтуудыг тодорхой тусгасан тусдаа эсвэл төсвийн баримт байж болно. Үүнийг засгийн газраас голдуу Сангийн яамнаас боловсруулдаг бөгөөд хөтөлбөр, төсөв жендэрт хэр анхаарч буйг харуулдаг. Төрийн байгууллагууд ялгаатай хөтөлбөрүүдэд төсөв, нөөцийг зарцуулж дууссаны дараа, жилийн тайлангийн мэдэгдэлд оруулж бэлтгэдэг.

“Үйл ажиллагааны ангилал” гэж тодорхойлж болно.

- Зорилго, зорилтуудын дагуух зардлын ангилал. Жендэр дэх үйл ажиллагааны ангилал нь жендэрийн асуудалд анхаарсан хөтөлбөр, үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг харуулна.

“Жендэрийн нөлөөллийн үнэлгээ” гэж тодорхойлж болно.

- Төсөвт нөөцийн хуваарилалт нь хэрэгжилтийн дараа ялангуяа жендэрийн эрх тэгш байдалд хэрхэн нөлөөлснийг үнэлсэн байна. Жишээ нь, нөөцийг зарцуулсны дараа бэлэн мөнгө шилжүүлэх нөхцөлт хөтөлбөр нь хөвгүүдтэй харьцуулахад охидын сургуульд хамрагдалтанд нөлөөлсөн үү?

“Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжсэн төсвийн бие даасан аудит хийсэн” гэж тодорхойлж болно.

- Жендэрийн эрх тэгш байдлыг дэмжиж тухайн жилийн төсвийн бодлогын дагуу төсөвтөө нэгдсэн төсвийн эрх мэдлээс ангид байгууллагаар бие даасан, бодитой дүн шинжилгээ хийлгэсэн.

Шалгуур 3-т:

“Хүртээмжтэй байдлаар хэвлэгдсэн” гэж тодорхойлж болно:

- Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх хуваарилалтын талаар Сангийн яамны вэб сайт (эсвэл албан ёсны төсөв хариуцсан хэлтэс)/холбогдох албан ёсны тогтмол хэвлэлээр олон нийтэд тодорхой мэдээлсэн, парламентын гишүүд, ТББ-дад хэвлэмэл байдлаар тараасан.

“Цаг тухайд нь хэвлэгдсэн” гэж тодорхойлж болно:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд зориулсан төсөв, хэрэгжилтийн талаар төсөв батлагдсан/гүйцэтгэл хийгдсэн тухай бүрт улирал бүр хэвлэн нийтэлсэн.



Аргачлал/тооцооны арга

Энэ үзүүлэлтийн мэдээллийг цуглуулахад дагалдах хяналтын удирдамж бүхий асуулгын хуудсыг ашиглана. Асуумжийн хуудсыг Үндэсний Статистикийн хороотой хамтран Сангийн яам, бусад холбогдох яам, Жендэрийн Үндэсний Хороо хариуцна.

Хэрвээ засгийн газраас жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдэлжүүлэхэд зориулсан төсөв хуваарилдаг системтэй бол асуумжийн хуудсыг Сангийн яам руу илгээнэ.

Шалгуур 1. Танай улсын Засгийн газрын хөтөлбөрүүд, нөөцийн хуваарилалтад улсын төсвийн дараах зарчмуудын аль нь тусгагдсан бэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)

Асуулт 1.1. Жендэрийн эрх, тэгш байдлыг дан ганц ерөнхий утга санаагаар (төрийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, дэд бүтэц гэх мэт) бус жендэрийн ялгааг арилгах нэгдсэн үйл ажиллагаа гэсэн санааг тодорхойлсон тэгш байдлыг хангах зорилго бүхий засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд байдаг уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 1.2. Эдгээр бодлого, хөтөлбөрүүдийн ерөнхий зорилго, жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудыг хангахад төсөвт нөөц хангалттай хуваарилагддаг уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 1.3. Эдгээр нөөцийг төсөвт үндэслэн хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа байна уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Шалгуур 2. Төрийн Санхүүгийн Удирдлагын тогтолцоо нь жендэртэй холбоотой, жендэрийн мэдрэмжтэй зорилтуудыг хэр их дэмждэг вэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)

Асуулт 2.1. Сангийн яам/төсвийн албанаас жендэрийн мэдрэмжтэй төсвийн хуваарилалтын талаар тодорхой удирдамж өгдөг үү? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 2.2. Төсөвт оруулахаар төлөвлөж буй гол бодлого, хөтөлбөрүүд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээнээс хамаардаг уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 2.3. Бодлого, хөтөлбөрүүдэд төсвийн холбогдолтой бодлогын шийдвэрийг тусгахад хүйсээр ангилсан статистик тоо баримтуудыг ашиглаж байна уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 2.4. Засгийн газар төсөвт тусгагдсан жендэртэй холбоотой зорилтуудын (жендэрийн төсвийн тухай мэдэгдэл буюу жендэрийн мэдрэмжтэй төсвийн тухай хууль тогтоомж)-ын талаар тодорхой ойлголт өгдөг үү? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 2.5. Төсвийн хуваарилалт нь жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудтай хамаарлаа тодорхой болгохын тулд үйл ажиллагааны ангилал хэлбэрээр тэмдэглэгддэг үү? (Тийм = 1 / Үгүй = 0)



Асуулт 2.6. Одоогийн гол бодлого, хөтөлбөрүүд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээний хувьд субъект болох уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 2.7. Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих цар хүрээг үнэлэхийн тулд улсын төсвийг бие даасан аудитад хамруулдаг уу? (Тийм = 1 / Үгүй = 0)

Шалгуур 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилготой төсвийн хуваарилалтыг олон нийтэд ил тод болгосон уу? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)

Асуулт 3.1. Жендэрийн эрх тэгш байдлын хуваарилалттай холбоотой мэдээлэл, тоо баримтууд хэвлэгдсэн үү? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 3.2. Хэвлэн нийтэлсэн тохиолдолд энэхүү мэдээллийг Сангийн яам (эсвэл төсвийн асуудал эрхэлсэн газар) вэбсайт болон/холбогдох албан ёсны бюллетенүүд болон олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэн нийтэлсэн үү? (Тийм = 1 / Үгүй = 0)

Асуулт 3.3. Хэрэв тийм бол жендэрийн тэгш байдлын хуваарилалтын талаарх мэдээллийг цаг тухайд нь хэвлэн нийтэлж байна үү? (Тийм = 1 / Үгүй = 0)

Оноо өгөх:

Улс бүр дараах байдлаар шалгуурыг хангасан гэж үзнэ:

Шалгуур бүрт тавигдах шаардлагууд	
Тухайн улс Шалгуур 1-ийг хангана	Шалгуур 1-ийн 3 асуултаас 2 асуултанд “Тийм” гэж хариулсан тохиолдолд
Тухайн улс Шалгуур 2-ыг хангана	Шалгуур 2-ын 7 асуултаас 4 асуултанд «Тийм» гэж хариулсан тохиолдолд
Тухайн улс Шалгуур 3-ийг хангана	Шалгуур 3-ын 3 асуултаас 2 асуултанд “Тийм” гэж хариулсан тохиолдолд

Шалгууруудын асуулт тус бүрт ижил жин өгнө. Тухайн шалгуурыг хангаж буй тохиолдолд асуулт болгонд «тийм» гэсэн хариултыг өгнө. Улмаар тухайн улсыг доорх матрицид дурдсан «Шаардлагыг бүрэн хангасан», «Шаардлагын заримыг нь хангасан», «шаардлагыг огт хангаагүй» гэсэн ангилалд хамруулна (Шалгуур үзүүлэлт хангагдах 8 тохиолдлууд байдаг A-G):

Шаардлагыг бүрэн хангасан	Шалгуур 1	Шалгуур 2	Шалгуур 3
Тохиолдол А	✓	✓	✓
Шаардлагын заримыг нь хангасан			
Тохиолдол В	✓		
Тохиолдол С		✓	
Тохиолдол D			✓
Тохиолдол E	✓	✓	
Тохиолдол F	✓		✓
Тохиолдол G		✓	✓
Шаардлагыг огт хангаагүй			
Тохиолдол H			

Тэмдэглэл: “Тэмдэглэгдсэн” нүд нь шалгуурыг хангасан болохыг илэрхийлнэ; «Тэмдэглэгдээгүй” нүд нь шалгуурыг хангаагүй болохыг илэрхийлнэ.

МОНГОЛ УЛСЫН ӨНӨӨГИЙН ОЛОЛТ, АМЖИЛТ

Үзүүлэлт 5.с.1 “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэхэд төсөв хуваарилдаг, хянах тогтолцоотой эсэх” гэсэн үзүүлэлтийн өнөөгийн хүрсэн түвшинг 3 шалгуур шаардлагыг хангаж буй эсэхийг НҮБ-ын аргачлалын дагуу үнэлэв. 2019 оны байдлаар Монгол улс 3 шалгуур шаардлагуудын заримыг нь хангасан амжилттай байна.

Шалгуур 1: ЖЭТБЭЭМ-д засгийн газраас анхаарч нөөцийг бодлого, хөтөлбөрүүдэд илүү хуваарилахад анхаарах. Хангасан.

Шалгуур 2: Засгийн газар төрийн санхүүгийн удирдлага, менежментийн циклээр дамжуулан ЖЭТБЭЭМ-д зориулж нөөцийг төлөвлөж, төсөвлөдөг бол үнэлэх. Хангаагүй.

Шалгуур 3: Засгийн газар ЖЭТБЭЭМ-д зориулж төсвийг хуваарилдаг бол түүнийг олон нийтэд ил тод болгоход анхаарах. Хангаагүй

Гурван шалгуурууд нь нэгэн адил ач холбогдолтой. Иймд Монгол Улс шаардлагыг бүрэн хангасан байхын тулд дээрх гурван шалгуурыг бүгдийг нь хангахад илүү хүчин чармайлалт гаргах хэрэгтэй байна.



ХҮСНЭГТ 1: ШАЛГУУР ШААРДЛАГУУДЫГ ХАНГАСАН БАЙДАЛ

	Шалгуур 1	Шалгуур 2	Шалгуур 3
Шаардлагын заримыг нь хангасан			
Монгол улс	✓		
Шаардлагын заримыг нь хангасан			
Сангийн яам	✓		
Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам	✓	✓	
Эрүүл Мэндийн Яам	✓	✓	
Хуул Зүй, Дотоод Хэргийн Яам	✓	✓	
Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам	✓		
Гадаад Харилцааны Яам		✓	
Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам	✓		
Байгаль орчин, Аялал Жуулчлалын Яам	✓		
Шаардлагыг огт хангаагүй			
Зам Тээврийн Хөгжлийн Яам			
Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам			
Барилга, Хот Байгуулалтын Яам			
Батлан Хамгаалах Яам			
Эрчим Хүчний Яам			

Тэмдэглэгээ: “Тэмдэглэгдсэн” нүд нь шалгуурыг хангасан болохыг илэрхийлнэ;

“Тэмдэглэгдээгүй” нүд нь шалгуурыг хангаагүй болохыг илэрхийлнэ.

ХҮСНЭГТ 2. ШАЛГУУР АСУУЛТУУД БА ХАРИУЛТ

Асуулт	Хариулт	Нотолгоо
Шалгуур 1. Танай улсын Засгийн газрын хөтөлбөрүүд, нөөцийн хуваарилалтад улсын төсвийн дараах зарчмуудын аль нь тусгагдсан бэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)		
1.1 Жендэрийн эрх, тэгш байдлыг дан ганц ерөнхий утга санаагаар (төрийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, дэд бүтэц гэх мэт) бус жендэрийн ялгааг арилгах нэгдсэн үйл ажиллагаа гэсэн санааг тодорхойлсон тэгш байдлыг хангах зорилго бүхий засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд байдаг уу?	Тийм	Монгол улс Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)-ийг баталсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг /2017-2021/ хэрэгжүүлж байна. Өнөөгийн байдлаар 6 яамд салбарын жендэрийн нэгдсэн бодлого, стратеги боловсруулан хэрэгжүүлж байна.
1.2. Эдгээр бодлого, хөтөлбөрүүдийн ерөнхий зорилго, жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудыг хангахад төсөвт нөөц хангалттай хуваарилагддаг уу?	Үгүй	
1.3. Эдгээр нөөцийг төсөвт үндэслэн хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа байна уу?	Тийм	Төсвийн тухай хууль /2011/-ийн 1, 6, 10-р зүйлд заасны дагуу бодлого, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа төсөвт үндэслэгдсэн эсэхийг баталгаажуулдаг.
Шалгуур 2. Төрийн Санхүүгийн Удирдлагын тогтолцоо нь жендэртэй холбоотой, жендэрийн мэдрэмжтэй зорилтуудыг хэр их дэмждэг вэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)		
2.1. Сангийн яам /төсвийн албанаас жендэрийн мэдрэмжтэй төсвийн хуваарилалтын талаар тодорхой удирдамж өгдөг үү?	Үгүй	
2.2. Төсөвт оруулахаар төлөвлөж буй гол бодлого, хөтөлбөрүүд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээнээс хамаардаг уу?	Тийм	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2017-2021 онд хэрэгжүүлж байгаа бөгөөд төлөвлөсөн үйл ажиллагаа, бодлогын арга хэмжээнүүд жендэрийн дүн шинжилгээнд суурилдаг.
2.3. Бодлого, хөтөлбөрүүдэд төсвийн холбогдолтой бодлогын шийдвэрийг тусгахад хүйсээр ангилсан статистик тоо баримтуудыг ашиглаж байна уу?	Үгүй	
2.4. Засгийн газарт төсөвт тусгагдсан жендэртэй холбоотой зорилтуудын (жендэрийн төсвийн тухай мэдэгдэл буюу жендэрийн мэдрэмжтэй төсвийн тухай хууль тогтоомж)-ын талаар тодорхой ойлголт өгдөг үү?	Үгүй	



Асуулт	Хариулт	Нотолгоо
2.5. Төсвийн хуваарилалт нь жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудтай хамаарлаа тодорхой болгохын тулд үйл ажиллагааны ангилал хэлбэрээр тэмдэглэгддэг үү?	Үгүй	
2.6. Одоогийн гол бодлого, хөтөлбөрүүд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээний хувьд субъект болох уу?	Тийм	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу салбаруудын жендэрийн асуудлаар бодлого, стратегийг жендэрийн дүн шинжилгээн дээр үндэслэн боловсруулан, хэрэгжүүлж байна. 2019 оны байдлаар 13 яамдаас 6 нь салбарын жендэрийн бодлого, стратегийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна. Нийслэл, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад жендэрийн хөгжлийн дэд хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх ажлуудыг эхлүүлсэн.
2.7. Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих цар хүрээг үнэлэхийн тулд улсын төсвийг бие даасан аудитад хамруулдаг үү?	Үгүй	
Шалгуур 3. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилготой төсвийн хуваарилалтыг олон нийтэд ил тод болгосон үү? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)		
3.1. Жендэрийн эрх тэгш байдлын хуваарилалттай холбоотой мэдээлэл, тоо баримтууд хэвлэгдсэн үү?		
3.2. Хэвлэн нийтэлсэн тохиолдолд энэхүү мэдээллийг Сангийн яам (эсвэл төсвийн асуудал эрхэлсэн газар) вэб хуудас болон/холбогдох албан ёсны бюллетенүүд болон олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэн нийтэлсэн үү?	Үгүй	
3.3. Хэрэв тийм бол жендэрийн тэгш байдлын хуваарилалтын талаарх мэдээллийг цаг тухайд нь хэвлэн нийтэлж байна үү?	Үгүй	

Хавсралт 1-д салбарын яамдын хүрсэн ололт, амжилтыг задлан харуулав.



ХАВСРАЛТ 1 ҮР ДҮН САЛБАРЫН ЯАМДААР

Асуултууд	Сангийн яам	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Эрүүл мэндийн яам	Хууль зүй дотоод хэргийн яам	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам	Гадаад харилцааны яам
Шалгуур 1: Танай улсын ЗГ-ын хөтөлбөрүүд, нөөцийн хуваарилалтад улсын төсвийн дараах зарчмуудын аль нь тусгагдсан бэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)	Хангасан	Хангасан	Хангасан	Хангасан	Хангасан	Хангаагүй
1.1 Жендэрийн эрх, тэгш байдлыг дан ганц ерөнхий утга санаагаар (төрийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, дэд бүтэц гэх мэт) бус жендэрийн ялгааг арилгах нэгдсэн үйл ажиллагаа гэсэн санааг тодорхойлсон тэгш байдлыг хангах зорилго бүхий ЗГ-ын бодлого, хөтөлбөрүүд байдаг уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
1.2 Эдгээр бодлого, хөтөлбөрүүдийн ерөнхий зорилго, жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудыг хангахад төсөвт нөөц хангалттай хуваарилагддаг уу?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
1.3 Эдгээр нөөцийг төсөвт үндэслэн хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа байна уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй
Шалгуур 2: Төрийн санхүүгийн удирдлагын тогтолцоо нь жендэртэй холбоотой, жендэрийн мэдрэмжтэй зорилтуудыг хэр их дэмждэг вэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)	Хангаагүй	Хангасан	Хангасан	Хангаагүй	Хангаагүй	Хангасан
2.1 Сангийн яам/төсвийн албанаас жендэрийн мэдрэмжтэй төсвийн хуваарилалтын талаар тодорхой удирдамж өгдөг үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй



Асуултууд	Зам тээвэр хөгжлийн яам	Хүнс ХАА хөнгөн үйлдвэрийн яам	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Бэрилгэ хот байгуулалтын яам	Батлан хамгаалахын яам	Эрчим хүчний яам
Шалгуур 1: Танай улсын ЗГ-ын хөтөлбөрүүд, нөөцийн хуваарилалтад улсын төсвийн дараах зарчмуудын аль нь тусгагдсан бэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)	Хангаагүй	Хангасан	Хангасан	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй
1.1 Жендэрийн эрх, тэгш байдлыг дан ганц ерөнхий утга санаагаар (төрийн үйлчилгээ, нийгмийн хамгаалал, дэд бүтэц гэх мэт) бус жендэрийн ялгааг арилгах нэгдсэн үйл ажиллагаа гэсэн санааг тодорхойлсон тэгш байдлыг хангах зорилго бүхий ЗГ-ын бодлого, хөтөлбөрүүд байдаг уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
1.2 Эдгээр бодлого, хөтөлбөрүүдийн ерөнхий зорилго, жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудыг хангахад төсөвт нөөц хангалттай хуваарилагддаг уу?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
1.3 Эдгээр нөөцийг төсөвт үндэслэн хэрэгжүүлж буй эсэхийг баталгаажуулах үйл ажиллагаа байна уу?	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
Шалгуур 2: Төрийн санхүүгийн удирдлагын тогтолцоо нь жендэртэй холбоотой, жендэрийн мэдрэмжтэй зорилтуудыг хэр их дэмждэг вэ? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)	Хангаагүй	Хангасан	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй
2.1 Сангийн яам/төсвийн албанаас жендэрийн мэдрэмжтэй төсвийн хуваарилалтын талаар тодорхой удирдамж өгдөг үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй



Хавсралт 1-ийн үргэлжлэл

Асуултууд	Сангийн яам	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Эрүүл мэндийн яам	Хууль зүй дотоод хэргийн яам	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам	Гадаад харилцааны яам
2.2 Төсөвт оруулахаар төлөвлөж буй гол бодлого, хөтөлбөрүүд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээнээс хамаардаг уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
2.3 Бодлого, хөтөлбөрүүдэд төсвийн холбогдолтой бодлогын шийдвэрийг тусгахад хүйсэр ангилсан статистик тоо баримтуудыг ашиглаж байна уу?	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
2.4 ЗГ төсөвт тусгасан жендэртэй холбоотой зорилтуудын (жендэрийн төсвийн тухай мэдэгдэл буюу жендэрийн мэдрэмжтэй төсвийн тухай хууль тогтоомж)-ын талаар тодорхой ойлголт өгдөг үү?	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм
2.5 Төсвийн хуваарилалт нь жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудтай хамаарлаа тодорхой болгохын тулд үйл ажиллагааны ангилал хэлбэрээ тэмдэглэдэг үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
2.6 Одоогийн гол бодлого, хөтөлбөрүүдэд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээний хувьд субъект болох уу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм



Асуултууд	Зам тзэвэр хөгжлийн яам	Хүнс ХАА хөнгөн үйлдвэрийн яам	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Барилга хот байгуулалтын яам	Батлан хамгаалахын яам	Эрчим хүчний яам
2.2 Төсөвт оруулахаар төлөвлөж буй гол бодлого, хөтөлбөрүүд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээнээс хамаардаг уу?	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
2.3 Бодлого, хөтөлбөрүүдэд төсвийн холбогдолтой бодлогын шийдвэрийг тусгахад хүйсээр ангилсан статистик тоо баримтуудыг ашиглаж байна уу?	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй
2.4 3Г төсөвт тусгасан жөндөртэй холбоотой зорилтуудын (жендэрийн төсвийн тухай мэдэгдэл буюу жендэрийн мэдрэмжтэй төсвийн тухай хууль тогтоомж)-ын талаар тодорхой ойлголт өгдөг үү?	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Үгүй
2.5 Төсвийн хуваарилалт нь жендэрийн эрх тэгш байдлын зорилтуудтай хамаарлаа тодорхой болгохын тулд үйл ажиллагааны ангилал хэлбэрээ тэмдэглэдэг үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
2.6 Одоогийн гол бодлого, хөтөлбөрүүдэд нь өмнөх жендэрийн нөлөөллийн үнэлгээний хувьд субъект болох үү?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм



Хавсралт 1-ийн үргэлжлэл

Асуултууд	Сангийн яам	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	Эрүүл мэндийн яам	Хууль зүй дотоод хэргийн яам	Боловсрол соёл шинжлэх ухаан спортын яам	Гадаад харилцааны яам
2.7 Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих цар хүрээг үнэлэхийн тулд улсын төсвийг бие даасан аудитад хамруулдаг уу?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Шалгуур 3: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилготой төсвийн хуваарилалтыг олон нийтэд ил тод болгосон уу? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй
3.1 Жендэрийн эрх тэгш байдлын хуваарилалттай холбоотой мэдээлэл, тоо баримтууд хэвлэгдсэн үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
3.2 Хэвлэн нийтэлсэн тохиолдолд энэхүү мэдээллийг Сангийн яам (эсхүл төсвийн асуудал эрхэлсэн газар) вэб хуудас болон/эсхүл холбогдох албан ёсны бюллетнууд болон олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэн нийтэлсэн үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
3.3 Хэрэв тийм бол жендэрийн тэгш байдлын хуваарилалтын талаарх мэдээллийг цаг тухайд нь хэвлэн нийтэлж байна үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй



Асуултууд	Зам тээвэр хөгжлийн яам	Хүнс ХАА хөнгөн үйлдвэрийн яам	Уул уурхай хүнд үйлдвэрийн яам	Байгаль орчин аялал жуулчлалын яам	Барилга хот байгуулалтын яам	Батлан хамгаалахын яам	Эрчим хүчний яам
2.7 Жендэрийн мэдрэмжтэй бодлогыг дэмжих цар хүрээг үнэлэхийн тулд улсын төсвийг бие даасан аудитад хамруулдаг уу?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
Шалгуур 3: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилготой төсвийн хуваарилалтыг олон нийтэд ил тод болгосон уу? (Сүүлийн санхүүгийн тайлангийн жилд)	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй	Хангаагүй
3.1 Жендэрийн эрх тэгш байдлын хуваарилалттай холбоотой мэдээлэл, тоо баримтууд хэвлэгдсэн үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
3.2 Хэвлэн нийтэлсэн тохиолдолд энэхүү мэдээллийг Сангийн яам (эсхүл төсвийн асуудал эрхэлсэн газар) вэб хуудас болон/эсхүл холбогдох албан ёсны боллетнууд болон олон нийтэд зориулсан мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэн нийтэлсэн үү?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй
3.3 Хэрэв тийм бол жендэрийн тэгш байдлын хуваарилалтын талаарх мэдээллийг цаг тухайд нь хэвлэн нийтэлж байна уу?	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй	Үгүй



АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Англи хэл дээр:

UNECE (2010). Developing Gender Statistics: a Practical Tool, United Nations Economic Commission for Europe, World Bank Institute.

https://unece.org/DAM/stats/publications/Developing_Gender_Statistics.pdf

UNSD (2016). Integrating a Gender Perspective into Statistics, Studies in Methods, Series F No. 111 Department of Economic and Social Affairs Statistics Division, United Nations, New York

<https://unstats.un.org/unsd/demographic-social/Standards-and-Methods/files/Handbooks/gender/Integrating-a-Gender-Perspective-into-Statistics-E.pdf>

UN, ECLAC (2020). The importance of gender mainstreaming in statistics for the public policy development Overcoming gender data gaps in the Caribbean to accelerate the implementation of the SDGS

https://www.cepal.org/sites/default/files/presentations/the_importance_of_gender_mainstreaming_in_statistics_for_the_public_policy_development_.pdf

Монгол хэл дээр:

БСШУЯ, АХБ, 2017. Дээд боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь” сургалтын гарын авлага, Улаанбаатар

Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо, 2020. Эрдэс баялгийн салбарын Жендэрийн сургалтын гарын авлага, хуудас 35. Монгол улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төсөл, СЕСМИМ төсөл, Улаанбаатар

Цахим хуудас:

Дэлхийн банк. 2022. Цахим мэдээллийн сан. <http://databank.worldbank.org>

НҮБ. 2022. Цахим мэдээллийн сан, Жендэрийн тэгш бус байдлын индекс (<https://data.un.org/Default.aspx>),

Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн байгууллага. 2022. <https://ilostat.ilo.org/data/>

ҮСХ. 2022. Статистикийн нэгдсэн мэдээллийн сан, Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл. <http://1212.mn>



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО





Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг



СУРГАЛТЫН МОДУЛЬ





АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	43
СУРГАЛТЫН МОДУЛИЙН ҮНДСЭН АГУУЛГА.....	46
СЭДЭВ 1: ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ БА АЧ ХОЛБОГДОЛ (30 минут)	47
СЭДЭВ 2: ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ (30 минут).....	52
СЭДЭВ 3: ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ (30 минут).....	54
ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ (5 минут)	56
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	58

ӨМНӨХ ҮГ

Үндэсний болон орон нутгийн, салбарын болон байгууллагуудын түвшинд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)-ийг хэрэгжүүлэх, үүнтэй уялдуулан баталсан үндэсний болон салбаруудын жендэрийн бодлого, стратегиудын гүйцэтгэл, хэрэгжилтийг хянах дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуурт жендэрийн үзүүлэлтүүд багтсан байх шаардлага зүй ёсоор тавигдаад байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 5.1.5-д жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчим, хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах мөн хуулийн 16.1.2-т хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийлгэх, түүний дүнг хэрэглэгч болон олон нийтэд хүргэж ажиллахыг заасан байдаг.

ЖЭТБХТХ-ийг хэрэгжүүлэх хугацаанд Монгол Улсын статистикийн салбарыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг 2011, 2017 онд хоёр удаа батлан гаргахдаа жендэрийн статистик мэдээллийн асуудлыг тусгасан нь ЖЭТБХТХ-ийн 5.1.5-д заасан жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчмыг хэрэгжүүлэх чухал алхам болжээ.

Нөгөө талаас төрийн бусад байгууллагууд захиргааны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, үр дүнг хэрэглэгч болон олон нийтэд хүргэх нөхцөлийг хангах тал дээр хангалтгүй ажиллаж байгаад дүгнэлт хийж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй бус байгаа нь жендэрийн мэдээлэлд үндэслэн төрийн бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд үнэлгээ дүгнэлт өгөх боломжгүйд хүрч, жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим, төрийн хариуцлагын зарчим алдагдахад хүргэж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн үр дагаварын үнэлгээгээр ЖЭТБХТХ-ийг хэрэгжүүлэх хугацаанд батлагдан гарсан төрийн бодлого, хууль тогтоомжид жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх зарчмыг тусгах, нэвтрүүлэх асуудал хангалттай бус байжээ.

Жендэрийн мэдээлэл хүртээмжтэй байх нь мэдлэгт суурилсан бодлого, түүний үр дүнтэй хэрэгжилтийг баталгаажуулсан үндсэн нөхцөл мөн учраас уг зарчмыг холбогдох хууль тогтоомжид тусгайлан тусгах, төрийн бодлого хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлагналтын бүхий л заавар журам, хэрэгсэлд хүйсээр ангилсан шалгуур үзүүлэлтүүдийг тусгах шаардлагатай.

Төрийн байгууллага захиргааны статистик мэдээллийг хүйсээр ангилж гаргах, дүн шинжилгээ хийж, үр дүнг хэрэглэгч болон олон нийтэд хүргэх нөхцөлийг хангах тал дээр хангалтгүй ажиллаж байгаад дүгнэлт хийж, институцийн чадавхыг эрс



сайжруулахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Төрийн бодлогын чанар, үр дүнгийн баталгаа болсон хүйсээр ангилсан статистик мэдээлэл хангалтгүй нь төрийн хариуцлагын зарчим хэрэгжихгүй, үүний улмаас жендэрийн мэдрэмжтэй бодлогын зарчим алдагдахад хүргэж байна.

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ноос Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ыг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг цуглуулах, боловсруулах, нэгтгэх, үр дүнг түгээх үйл ажиллагааг сайжруулах зорилгын хүрээнд жендэрийн статистикийг бий болгох, хөгжүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээнүүдийг 2016 оноос эрчимтэй хэрэгжүүлсээр байна.

Жендэрийн статистикийг явцуу утгаар нь жендэрийн хэвшмэл сэтгэлгээ, төсөөллийг өөрчилж, жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого боловсруулах үйл явц гэж ойлгож болно. Харин өргөн утгаараа энэ нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдрал, жендэртэй холбоотой бодлогын үнэн зөв, бодит байдлыг тусган илэрхийлсэн статистикийг тодорхойлох, мэдээлэл цуглуулж, бий болгох, нэгтгэн дүгнэх, тархаах үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, тоо мэдээллийг дан ганц хүйсээр ангилснаараа жендэрийн статистикийг бий болголоо гэж ойлгох бус түүнийг олон улсын болон үндэсний стандарт, арга, аргачлалын дагуу зөв тодорхойлж, цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүн шинжилгээ хийх, хэрэглэгч, шийдвэр гаргагчдад хамгийн ойлгомжтой байдлаар хүргэх, тархаах цогц үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд ЖҮХ-ны салбар зөвлөл, салбар хороо нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар авч хэрэгжүүлсэн тухайн жилийн үйл ажиллагааны болон хүйсийн тэнцвэрт байдлыг талаарх тайланг дараа оны 02 сарын 10-ны дотор, аймаг, нийслэл, дүүргийн ИТХ нь ЖЭТБХ төрийн бодлогын хэрэгжилтийн тайланг дараа оны 02 сарын 20-ны дотор тус тус Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэхээр заасан байдаг. Дээрх 3 төрлийн тайланг ЖҮХ-ны Ажлын алба хүлээн авч, нэгтгэх боловсруулж, хорооны хуралдаанд танилцуулсны дагуу хороо энэхүү тайлангийн талаар дүгнэлт гаргаж, Засгийн газрын хуралдаанд оруулдаг билээ.

Энэ нь Монгол Улсын Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах асуудлын хүрээнд хийсэн ажлаа үнэлэх, ололт, амжилт, дутагдалаа олж илрүүлэх, дараагийн жилд хийх ажлыг зорилт, үйл ажиллагаагаа төлөвлөхөд дээрх 3 төрлийн тайлан чухал ач холбогдолтой.

Монгол Улсын жендэрийн үндэсний тогтолцоо нь ЖЭТБХ-т хуулийг Монгол Улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, нэгжүүдийн үйл ажиллагааны нэгдэл юм. Энэхүү тогтолцоог үндэсний аймаг, нийслэлийн, сум, дүүргийн гэсэн төрийн эрх мэдлийг хуваарилан гүйцэтгэх түвшингээр харах боломжтой үндэсний хэмжээний сайн туршлага бий болоод байна.



Иймд, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн бодлого боловсруулах, төлөвлөх, шийдвэр гаргахад оролцогч талууд ялангуяа удирдах албан тушаалтан, менежерүүд, ажилчдын эрх ашгийг хамгаалах эвсэл, холбоодын тэргүүлэгчид, шийдвэр гаргагчдад зориулан энэхүү сургалтын модулийг, унших материалын хамт бэлтгэн боловсруулж, та бүхэнд толилуулж байна.

Түүнчлэн, энэ сургалтын модуль, унших материалыг ашиглан сонирхогч талуудад зориулсан жендэрийн статистикийг бий болгох, хөгжүүлэх чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах боломжийг төв болон орон нутгийн төрийн албад, холбогдох агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагуудад олгож байна.



СУРГАЛТЫН МОДУЛИЙН ҮНДСЭН АГУУЛГА

Сургалтын зорилго ба хүлээгдэж буй үр дүн:

- Жендэрийн статистикийн ач холбогдлыг ойлгож, жендэрийн статистикийг бий болгож хөгжүүлэх, ашиглах мэдлэгтэй болно.
- Нийгмийн амьдрал, хөгжлийн үйл явц эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн ялгаатай нөлөөлж буйг илрүүлэх, жендэрт суурилсан ижил болон ялгаатай, тэгш болон тэгш бус байдлын цар хүрээг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, үр дүнг шинжлэн дүгнэх, тайлагнах мэдлэг, үр чадвар эзэмшинэ.
- Аливаа бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаандаа жендэрийн үзэл баримтлалыг тусгах жендэрийн мэдрэмжтэй хандлагыг төлөвшүүлнэ.

Зориулалт: Төв болон орон нутгийн төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах алба тушаалтан, менежерүүд, байгууллагын нийгэм, жендэрийн асуудал хариуцсан ажилтнууд

Хичээлийн агуулга	<ul style="list-style-type: none">- Жендэрийн статистикийн тухай ойлголт, хэрэглээ ба ач холбогдол- Жендэрийн статистикийг цуглуулах аргууд- Жендэрийн статистикт дүн шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах
Өөрийн үнэлгээ	Мэдлэг баталгаажуулах сорилын тест бөглөх (5 минут)
Дүгнэлт	Сорилын зөв, буруу хариултыг тайлбарлан, ойлголтоо нэгтгэх (10 минут)
Үргэлжлэх хугацаа:	2 цаг
Бэлтгэх шаардлагатай зүйлс:	Сэдвийн үндсэн агуулгаар бэлтгэгдсэн слайдууд. Техник хэрэгсэл Самбар/цаас, шохой/самбарын үзэг Дасгалын даалгаврыг оролцогчийн тоогоор хувилсан байна.

СЭДЭВ 1: ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХЭРЭГЛЭЭ БА АЧ ХОЛБОГДОЛ

(30 минут)

Үйл ажиллагаа 1.1:

Жендэрийн статистикийг хүйсээр ангилагдсан тоо мэдээллээс ялгаж ойлгох нь

Зохион байгуулалт: Хүйсээр ангилсан мэдээллийг өөрийн ажилдаа хэрхэн ашигладаг талаар оролцогчидтой ярилцаж, хариултыг бүлэглэнэ. Үр дүнг оролцогчдод товч танилцуулна.

Цуглуулсан мэдээллүүд нь ямар шинж чанарыг агуулсан байдаг талаар оролцогчдоос тодруулан асууж, хариултуудыг Хүснэгт 1-д хариулт өгсөн оролцогчдын тоогоор нэгтгэн тэмдэглэж, үр дүнг товч танилцуулна. Хичээл эхлэхээс өмнө оролцогчдын ойлголт, мэдлэг, хэрэглээ хэр байгааг эхлээд тогтооно.

ХҮСНЭГТ 1. ХҮЙСЭЭР АНГИЛАГДСАН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА БА ХЭРЭГЛЭЭ

Хариултын нэгтгэл	Хариулт		
	Зөв хариулт	Дутуу хариулт	Огт хариулаагүй
- Мэдээллийг хүйсээр ангилан цуглуулж, үр дүнг танилцуулдаг.			
- Цуглуулагдсан мэдээлэл жендэрийн асуудлыг тусгасан байдаг.			
- Цуглуулсан мэдээлэл нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн олон талт байдлыг хангалттай тусгаж, тэдний амьдралын бүхий л талыг хамарсан ойлголт, тодорхойлолтод үндэслэсэн байдаг.			
- Мэдээлэл цуглуулах аргууд нь мэдээлэл, тоон өгөгдөлд жендэрийн гажуудлыг өдөөж болох хэвшмэл ойлголт, нийгэм, соёлын хүчин зүйлсийг харгалзан үзсэн байдаг.			

Үйл ажиллагаа 1.2:

Жендэрийн статистикийн тодорхойлолт, жендэрийн статистикийг хөгжүүлэх, түүнийг бодлого, үйл ажиллагаанд ашиглаж буй талаар олон улсын болон үндэсний түвшний жишээгээр слайд ашиглан багш товч танилцуулна.

Ойлголт, тодорхойлолтууд

Жендэрийн статистик нь амьдралын бүхий л салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн нөхцөл байдлын ялгаа, тэгш бус байдлыг хангалттай тусгадаг.

Жендэрийн статистик нь Жендэрийн тулгамдсан асуудлуудыг илүү тодорхой ойлгох, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тооцох, улмаар жендэрийн тэгш байдалд



нөлөөлж буй нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсийн хоорондын уялдаа холбоо, үр дагаварыг тогтоох арга хэрэгсэл юм. Хөгжлийн болон ядуурлыг бууруулах бодлогод жендэрийн чиг хандлагыг тусгахад чухал үүрэгтэй бөгөөд тэгш бус байдлыг илрүүлж, ядуурлын хэмжигдэхүүнүүдийн талаар илүү өргөн хүрээтэй ойлголтыг өгдөг. Иймд энэ нь эргээд бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг өөрчлөх боломжийг олгодог.

Хүйсээр ангилагдсан тоо баримт гэдэг нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээнд үндэслэсэн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, бодлого, төлөвлөлтийн үр нөлөө эмэгтэй, эрэгтэй хүмүүст хэрхэн, ямар байдлаар нөлөөлж буйг нягтлан шинжлэхэд ашиглах статистик үзүүлэлт юм.

Жендэрийн мэдрэмжтэй статистик нь тоо, мэдээ, мэдээллийг хүйсийн задаргаатай цуглуулахаас өргөн хүрээний үйл ажиллагаа бөгөөд хөгжлийн олон асуудлыг шийдвэрлэх хүрээнд жендэрийн ялгаатай байдлыг арилгах гол зэвсэг болдог. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бодит байдлыг гаргаж өгснөөрөө жендэрээс үүдэлтэй олон нийтийн хэвшмэл буруу ойлголтыг засч залруулах, эерэг болгоход тусалдаг. Мөн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулахад чиглэсэн, дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн зорилгод хүрэх үйл явцыг үнэлэх үнэн бодит, харьцуулагдахуйц мэдээллийн суурь болдог.

Жендэрийн статистикийг явцуу утгаар нь хэвшмэл сэтгэлгээ, төсөөллийг өөрчилж, тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого боловсруулах үйл явц гэж ойлгож болно. Харин өргөн утгаар нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн амьдрал, жендэртэй холбоотой бодлогын үнэн зөв, бодит байдлыг тусган илэрхийлсэн статистикийг тодорхойлох, гаргах, нэгтгэн дүгнэх, тархаах үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, тоо мэдээллийг дан ганц хүйсээр ангилснаараа жендэрийн статистикийг бий болголоо гэж ойлгох бус түүнийг олон улсын болон үндэсний арга, аргачлал, стандартын дагуу зөв тодорхойлж, цуглуулах, боловсруулах, үр дүнг нэгтгэн дүн шинжилгээ хийх, хэрэглэгч, шийдвэр гаргагчдад хамгийн ойлгомжтой байдлаар хүргэх, тархаах үйл ажиллагааны цогц юм.

Жендэрийн статистикийг бий болгох, хөгжүүлэх нь янз бүрийн мэдээллийн эх сурвалж, статистикийн салбаруудын оролцоо бүхий үндэсний статистикийн тогтолцоог бүхэлд нь хамардаг. Ингэхдээ зөвхөн хүйсээр нь ангилсан статистикийн эмхэтгэлээр хязгаарлаж буй ташаа ойлголтыг залруулж, янз бүрийн салбарын жендэрт чиглэсэн статистикийн үзүүлэлтүүдийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, үр дүнг хэвлэх, тайлагнах, мэдээллийн сан үүсгэх зэрэг үндэсний статистикийн системээс гаргадаг бусад статистик мэдээллүүдийн нэгэн адил үе шатуудаар хийгдэнэ.



Жендэрийн статистикийн хэрэглээ ба ач холбогдол

Дэлхийн эмэгтэйчүүдийн дөрөвдүгээр бага хурал (Бээжин 1995) *жендэрийн статистикийн* хөгжлийн талаар чухал үр дүнд хүрснээр анх удаа олон улс үндэстэн жендэрийн статистикийг бий болгох, тархаах асуудлыг өргөн хүрээнд авч үзэх болсон. Засгийн газрууд “хүйсээр ангилагдсан, төлөвлөлт, үнэлгээ хийх бололцоог хангасан мэдээллийг цуглуулах, боловсруулах, тархаах”-д онцгой ач холбогдол өгч, үйл ажиллагааг эрчимжүүлэх амлалтаа өгсөн.¹ Улмаар засгийн газрууд болон бусад субъектээс бүх стратеги бодлого, хөтөлбөрийн хүрээн дэх үйл ажиллагааны үндсэн чиглэлдээ эмэгтэйчүүдийн асуудлыг тооцон үзэж, идэвхтэй, тодорхой зорилготой бодлого явуулах, ингэхдээ шийдвэр гаргахаасаа өмнө эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдэд үзүүлэх үр дагаварт дүн шинжилгээ хийсэн байхыг шаардаж эхэлсэн юм.

Жендэрийн бодлого нь өөрчлөлтөд чиглэсэн давхар оролцооны илэрхийлэл болдог. Тухайлбал, нийгэм, соёл, эдийн засаг, улс төрийн ялгаатай байдлыг харгалзан улс үндэстэн доторх болон гаднах үйл явцын эрэгтэй, эмэгтэй хүмүүст үзүүлэх нөлөөг илэрхийлдэг. Жендэрийн эрх тэгш байдлын үзэл баримтлал нь ялангуяа эмэгтэйчүүд, охид эсвэл өндөр настай эмэгтэйчүүдэд зориулагдсан үйлдлийг орлох бус харин тодорхой бодлогоор дамжуулан жендэрийн эрх тэгш байдлын нийтлэг ойлголтыг дэмжиж, тэгш байдлын давхар хэмжүүрийг бүрдүүлэхүйц тэгш байдлын бодлогыг агуулж байдаг (UNSD, 2016).

Жендэрийн статистик нь нийгэм, соёл, эдийн засаг, улс төр зэрэг бүхий л салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцоо, хувь нэмрийг баримтжуулж, жендэрийн тэгш бус байдлын үндсэн шалтгаан, үр дагаврыг тусгахад ашиглагддаг. Иймд үндэсний статистикийн системээр дамжуулан жендэрийн холбогдох асуудлыг хөндсөн мэдээллийг тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийж, түгээх шаардлагатай.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь хүний эрхийн асуудал төдийгүй, хүн төвтэй тогтвортой хөгжлийн тулгуур үндэс гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч, жендэрийн тэгш эрх хэрэгжих, нөхцөл бололцоог хууль тогтоомжоор баталгаажуулж байна.

Статистикийн уламжлалт салбаруудад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн бодит амьдралтай холбогдолтой, жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, бодлоготой хамаарал бүхий статистик мэдээллийг олж илрүүлэн, боловсруулж, тараан түгээхийг ойлгоно.

Жендэрийн статистикийг боловсронгуй болгохын зэрэгцээ нийгэм дэх жендэрийн тэгш бус байдлыг арилгах, нийгэм, эдийн засаг, соёлын салбарын шинжилгээний асуудлыг хамарна.

¹ НҮБ, 1996. Бээжингийн тунхаглал болон үйл ажиллагааг хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Стратегийн зорилтууд, Төлөвлөлт, үнэлгээнд зориулан хүйсээр ангилсан тоо баримт, мэдээлэл цуглуулж тараах.



Жендэрийн тэгш байдлыг хангах стратеги нь мэдээлэл хэрэглэгч болон мэдээлэл гаргаж байгаа талуудын нягт хамтын ажиллагаа, үндэсний статистикийн газар болон үндэсний статистикийн тогтолцооны дотоод уялдаа холбоо, үндэсний статистикийн газар болон үндэсний бусад агентлаг хоорондын мэдээлэл солилцох гэрээнд суурилсан байх шаардлагатай.

Олон улсын практикт жендэр статистикийг хөгжүүлснээр нийгэм, жендэрийн хөгжлийн зорилго, зорилтуудыг хангахад ашиглаж байна. Тухайлбал:

- Үр ашигтай шийдвэр гаргахад шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах, боловсруулах, нэгтгэн дүгнэх, дүн шинжилгээ хийх, тайлбарлах, танилцуулдаг.
- Жендэрийн статистик нь бүх төрлийн нөөцийн хүртээмж дэх жендэрийн тэгш бус байдлыг бууруулахад чиглэгдсэн бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үндэслэл бүхий нотолгоог гаргаж тавьдаг.
- Жендэрийн статистик нь жендэрийн тэгш бус байдлын илэрхийлэл, ялгаатай байдлын цар хүрээ, эрч хүчийг харуулдаг хүчирхэг хэрэгсэл болдог.
- Өөрчлөлтийг дэмжих зорилгоор тэдгээрт шаардлагатай арга хэмжээ авах боломжийг олгож, тэгш бус байдлын илрэлүүдэд нөлөөлж болохуйц янз бүрийн үндсэн шалтгааныг тодорхойлоход тусалдаг.
- Жендэрийн статистик нь нийгэм дэх эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн бодит байдлыг ойлгоход тусалдаг.
- Жендэрийн статистик нь эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн оруулсан хувь нэмрийг тодорхой харуулсан хүний үйл ажиллагааны талбаруудыг харуулдаг.
- Жендэрийн статистик нь ядуурлыг бууруулахад жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг бодлогын хэрэгсэл болдог.
- Жендэрийн статистикийн мэдээллийг олон нийтэд түгээх нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бууруулахад маш чухал нөлөөтэй. Түүнчлэн, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, нийгэмд оруулах хувь нэмрийг зөвөөр тайлбарлах гэр бүл, ажлын байран дахь үүргийн хуваарилалтад жендэрийн шинэ тэнцвэрийг бий болгох шийдвэр гаргах байр суурийг илэрхийлдэг.
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах бодлого боловсруулах, хянахад жендэрийн статистик чухал үүрэг гүйцэтгэдэг.
- Жендэрийн статистик нь эдийн засаг, олон нийтийн амьдрал болон улс төрийн шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хянах боломжийг олгодог.



- Эмэгтэйчүүдийн бүрэн, үр дүнтэй оролцоог хангах, бүх түвшинд манлайлах тэгш боломжийг бий болгохын тулд улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралд шийдвэр гаргахад жендэрийн статистикийг ашигладаг.

Монгол Улсын хувьд, ҮСХ-ноос албан ёсны статистикийн мэдээлэл болон захиргааны статистикийн мэдээллийг ашиглан ТХЗ 5: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилгыг хүрээнд дэвшүүлсэн 9 зорилт, тэдгээрийг хэмжих 14 үзүүлэлтээс 6 үзүүлэлт одоогоор гараагүй байна. ҮСХ нь бие даан гаргах боломжтой ТХЗ-ын үзүүлэлтүүдийг гаргах аргачлалыг сайжруулах, бусад яам, агентлагуудтай хамтран боловсруулах үзүүлэлтүүдийг гаргах аргачлалыг сайжруулах зорилгоор уламжлалт болон уламжлалт бус мэдээллийн эх үүсвэрүүдийг ашиглан жендэрийн статистикийг хөгжүүлэх чиглэлд олон улсын техник, санхүүгийн дэмжлэг авч хамтран ажиллаж байна.

Байгууллагын түвшинд жендэрийн статистикийг бий болгох, ашиглах

Байгууллагын хөгжлийн бодлогод жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг тусгахдаа эн тэргүүнд жендэрийн талаас анхаарвал зохих ямар асуудлыг шийдэх ёстой гэдгээ тодорхойлох шаардлагатай. Ямар асуудлыг шийдэх шаардлагатайг үндэслэх, тухайн асуудлыг шийдэхэд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг тодруулахдаа хүйсээр ангилсан тоон мэдээ, баримт, мэдээлэлд суурилсан жендэрийн дүн шинжилгээнд тулгуурлана. Ялангуяа жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалд тулгуурлан асуудлыг тодорхойлоход хүйсээр ангилсан мэдээ, баримт, нотолгоо чухал үүрэгтэй. Иймд байгууллага нь удирдлага, менежментийн тогтолцоондоо хүйсээр ангилсан мэдээллийг өргөн хүрээнд цуглуулж, мэдээллийн сан үүсгэн, түүнийгээ шинжилдэг, ашигладаг байх шаардлагатай.

**СЭДЭВ 2: ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКИЙГ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙ**

(30 минут)

Үйл ажиллагаа 2.1:

Салбарын байгууллагуудаас ажиллагсдынхаа ажил-ар-гэрийн тэнцвэрт байдлыг хангадаг эсэхийг мэдээллийн ямар эх үүсвэр ашиглаж цуглуулах боломжтой талаар оролцогчдоос асууж, ярилцана. Дараа нь доорх шалгах хуудсыг бөглүүлнэ.

Шалгах хуудас: Ажил-гэрийн зохистой тэнцвэрийг хангах

№	Шалгуур	Тийм	Үгүй
1	Хүний нөөцийн бодлогод “ажил-гэрийн зохистой тэнцвэр”-ийг хангах талаар тодорхой зохицуулалт бий эсэх		
2	Бага насны хүүхэдтэй эх, эцэгт хөнгөрүүлсэн, уян хатан байдлаар хөдөлмөрийн гэрээ байгуулах боломж бий эсэх		
3	Ажлын цаг, ачаалал нь гэр бүлийн үүргээ биелүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн эсэх		
4	Бага насны болоод сургуулийн бага ангийн насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд ажлын цагийн уян хатан зохицуулалт бий эсэх		
5	Хүүхэд болон гэр бүлийн гишүүнээ асран халамжлах зорилгоор цалинтай болон цалингүй чөлөө авах боломж бүрдсэн эсэх		
6	Сургуультай ойр хүүхэд асрах хүртээмжтэй, үйлчилгээг нэвтрүүлсэн эсэх (багш, ажилтан, оюутнуудад)		
7	Сургуультай ойр сургууль, боловсролын хүртээмжтэй, үйлчилгээг нэвтрүүлсэн эсэх (багш, ажилтан, оюутнуудад)		
8	Үүрэг даалгавраа уян хатан цагаар эсхүл гэрээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлсэн эсэх		

Ажиллагсдынхаа гэр бүлийн үүрэг хариуцлагаа биелүүлэхэд анхаарсан, уян хатан бодлоготой эсэх нь ажлын ачаалал, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үнэлгээнд нөлөөлнө. Жишээ нь, бага насны хүүхдээ асран халамжлах шаардлагатай эх, эцэгт хөдөлмөрийн гэрээгээ хөнгөрүүлсэн нөхцөлтэйгээр (50% г.м) байгуулах боломжтой тохиолдолд гэр бүлийн үүрэг хариуцлагаа биелүүлэх эерэг таатай нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж үзнэ.

Шалгах хуудсанд тусгасан бодлого, зохицуулалт үгүй тохиолдолд байгууллагын болон салбарын үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтран “Хамтын гэрээ” байгуулахдаа зохих бодлого, зохицуулалтыг тусгах чиглэлээр анхаарлаа хандуулж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлд талууд хамтран ажиллах шаардлагатай гэсэн үг юм.

Үйл ажиллагаа 2.2:

Жендэрийн статистикийг цуглуулах арга зүйн талаар слайд ашиглан багш тайлбарлана.

Жендэрийн статистикийг бий болгох үйл явц нь бусад статистикийн нэгэн адил харилцан уялдаа бүхий олон төрлийн үйл ажиллагааг хамардаг. Эдгээр үйл ажиллагаа бүр, тэдгээрийн уялдаа холбоо нь эцсийн бүтээгдэхүүний чанарт ихээхэн нөлөөлдөг. Тиймд бүх үйл ажиллагааг үр дүнтэй, зөрчил, саадгүй, нягт уялдуулсан нэгдсэн багцыг бүрдүүлэхийн тулд жендэрийн статистик бий болгох үйл явцыг эхнээс нь төгсгөл хүртэл цогцоор нь харж, маш сайн нарийн тодорхойлсон зорилтууд, тэдгээрийг зөв үнэлэх хэмжигдэхүүнийг тогтоох хэрэгтэй.

Жендэрийн статистикийг бий болгох үйл явц нь өргөн утгаараа статистикийн бусад салбарынхтай төстэй бөгөөд дараах үндсэн алхмуудаар хийгдэнэ. Тухайлбал,

- Судлах шаардлагатай сэдвүүдийг сонгох;
- Амьдралын янз бүрийн салбарт жендэрийн ялгаа, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн үүрэг, хувь нэмрийг ойлгоход шаардлагатай баримт, тоон өгөгдлийг тодорхойлох;
- Нийгэм дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн олон янз байдлыг зохих ёсоор тусгасан шинэ үзэл баримтлал, тодорхойлолт, аргачлалыг шаардлагатай бол боловсруулах;
- Мэдээлэл цуглуулах арга, загварыг сонгох: мэдээлэл цуглуулах нэгжийг сонгох; түүврийн хэмжээг тодорхойлох, асуулгын хуудас, ярилцлагын удирдамж гэх мэт судалгааны хэрэглэгдэхүүнийг боловсруулан түрших; асуулга авагчдыг сургаж бэлтгэх;
- Статистик мэдээг ашиглахад хялбар хэлбэрээр дүн шинжилгээ хийх, танилцуулах; статистикаар гарч ирсэн үр дүнг бодлого боловсруулагчид, төлөвлөгчдөөс гадна өргөн хүрээний хэрэглэгчдэд түгээх.

Байгууллагын түвшин дэх хүйсээр ангилсан дараах мэдээллийг тодорхой цаг хугацааны хүрээнд (улирал, хагас жил эсвэл жил г.м) тогтмол цуглуулж, дүн шинжилгээ хийж, үр дүнг ил тод мэдээлж байх шаардлагатай.

Хүйсээр ангилсан тоон болон чанарын мэдээллийг цуглуулсны дараагаар дүн шинжилгээ хийн, зохих ялгаа илэрсэн бол ямар шалтгаантай болох, ямар үр дагавар гарч болохыг нягталж, холбогдох өөрчлөлтийг төлөвлөнө.



СЭДЭВ 3: ЖЕНДЭРИЙН СТАТИСТИКТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ

(30 минут)

Үйл ажиллагаа 3.1

Багш слайд ашиглан жендэрийн статистикт дүн шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах талаар тайлбарлана.

Үндэсний статистикийн бүх систем хүйсээр ангилсан статистик үзүүлэлтийг гаргахыг зорьж байна. Гэсэн хэдий ч гаргаж авсан бүх мэдээлэл нь тухайн нийгэм дэх жендэрийн асуудлыг тусгах, дүн шинжилгээ хийхэд хангалтгүй, мөн тэдгээрийг түгээх, тайлбарлахдаа жендэрийн ялгаа, түүний шалтгааныг онцолж чадахгүй байх явдал элбэг тохиолдож байна. Цаашилбал, тухайн улс орны бодлого боловсруулагчид эсвэл төлөвлөгчдийн хувьд чухал гэж үздэг жендэрийн зарим асуудлыг үндэсний статистикийн системээс гаргаж буй мэдээллээр гаргах боломжгүй байна.

Иймд, үндэсний хэмжээнд тодорхойлсон жендэрийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай статистик мэдээ болон үндэсний статистикийн тогтолцооноос шалтгаалан одоогийн байдлаар гаргаж буй статистикийн хоорондын зөрүүг тодорхойлж, жендэрийн статистикийг сайжруулах үндэслэл болгож болно. Харгалзан үзэх шаардлагатай жендэрийн асуудал, тэдгээрийг шийдвэрлэхэд хэрэгтэй байгаа жендэрийн статистикийн талаар тэргүүлэх чиглэлийг тодорхойлох нь өнөөгийн бодлогын зорилго, төлөвлөгөө, хэмжилтийн аргачлалаас мөн хамаарна.

Анхаарал хандуулах шаардлагатай жендэрийн нийтлэг асуудлын хувьд дэлхийн болон бүс нутгийн түвшинд загваруудыг гаргаж өгдөг. Тухайлбал, Бээжингийн үйл ажиллагааны тунхаглал нь ядуурал, боловсрол, сургалт, эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөн, эдийн засаг, эрх мэдэл, шийдвэр гаргах түвшин, охид, эмэгтэйчүүдийн эрх, хэвлэл мэдээлэл, байгаль орчин зэрэг санаа зовоосон хэд хэдэн чухал салбарыг тодорхойлсон. Бүс нутгийн түвшинд ч мөн жендэрийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Мөн НҮБ-ээс тогтвортой хөгжлийн зорилтуудад дэвшүүлсэн жендэрийн чанарын үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, удирдамжуудыг боловсруулан, улс үндэстний түвшинд тооцоолох үндэсний чадавхыг бэхжүүлэх арга хэмжээг авч байна.

Тухай улс үндэсний түвшинд жендэрийн асуудлаар тэргүүлэх чиглэлийг статистикчид болон статистикийн гол хэрэглэгчидтэй зөвлөлдөх үүлзалтууд зохион байгуулж тодорхой болгох нь нэн чухал юм. Тухайн асуудалд илүү гүнзгий дүн шинжилгээ хийхийн зэрэгцээ анхаарч үзэх шаардлагатай жендэрийн асуудлаарх үндэсний тэргүүлэх чиглэлүүд нь тухайн улс оронд шаардлагатай байгаа жендэрийн статистикийн үзүүлэлтийн үндэс болдог. Учир нь асуудлын шалтгаан, үр дагавар нь статистикийн сонголт, мэдээлэл цуглуулах аргуудад нөлөөлөх тул нэн тэргүүний зорилтуудын нэг болох эсэхийг шийдэх нь чухал юм.

Жендэрийн дүн шинжилгээгээр илрүүлсэн үр дүн, үнэлгээ нь үндэсний статистикийн газраас гаргасан тогтмол болон жендэрт чиглэсэн үр дүнгийн хүснэгт, мэдээллийн танилцуулга, түгээлттэй танилцах замаар цуглуулсан мэдээллийг боловсруулж, холбогдох шинж чанараар нь ангилж, түгээх боломжтой эсэхийг тодорхойлно. Мэдээллийн одоо байгаа эх сурвалж, түгээх бүтээгдэхүүний үнэлгээний үндсэн дээр статистикчид шаардлагатай жендэрийн статистикийн эхний үе шатанд мэдээллийн зөрүүг тодорхойлж, (а) одоо байгаа өгөгдлийг илүү сайн ашиглах эсвэл дахин боловсруулах шаардлагатай эсэхийг шийдэх боломжтой. Дэд өгөгдлийг дахин кодлох, дахин тоолох эсвэл дахин дүн шинжилгээ хийх; (б) одоо байгаа мэдээлэл цуглуулах аргачлалыг сайжруулах; (в) цоо шинэ хэрэглэгдэхүүн эсвэл одоо байгаа хэрэглэгдэхүүнд нэмэлт мэдээлэл оруулж цуглуулах шаардлагатай.

Үр дүн:

- Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах үндэс болно
- Жендэрийн эрх тэгш байдлын төлөв байдал, бодлогын үр нөлөөг үнэлэх, бодлогын хэрэгжилтийг үнэлнэ.
- Мэдээллийн чанар, уялдаа холбоо сайжирна
- Салбарын бодлогын арга хэмжээг төлөвлөх үндэс болно
- Жендэрийн мэдээллийн нэгдсэн сан байгуулах суурь болно
- Бодлого боловсруулагч болон хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангана.

Үйл ажиллагаа 3.2.

Унших материалын Хавсралт-1 Үлгэрчилсэн жишээ: Тогтвортой хөгжлийн жендэрийн зорилтуудыг хэмжих чанарын үзүүлэлтийг хэрхэн тооцсон аргачлалтай танилцахыг хүснэ.



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

(5 минут)

Мэдлэг шалгах сорил

Та асуулт бүрт оновчтой зөвхөн нэг хариултыг сонгоно уу.

1. Жендэрийн тэгш байдлыг хангах бодлого, стратеги нь . . . нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулна.
 - a) Хүмүүсийн хэрэгцээг хангаж байвал
 - b) Бодлого, үйл ажиллагааны үр шимийг хүн бүр хүртэж байвал
 - c) Нөөц баялгийг үр ашигтай ашиглан, нэмэгдүүлж байвал
 - d) Баялгийг хэрэгцээтэй үед нь ашиглаж байвал
2. Жендэрийн статистикт аль нь үл хамаарах вэ?
 - a) Эмэгтэйчүүдийн дуу хоолойг сонсох
 - b) Тэгш бус байдлыг илрүүлэх
 - c) Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн хэрэгцээг тодорхойлох
 - d) Эмэгтэйчүүдийг чадавжуулах, эрх мэдэл олгох
3. Жендэрийн статистик цуглуулах мэдээллийн эх үүсвэрүүд нь
 - a) Хүн амын мэдээллийн анхдагч болон хоёрдогч эх үүсвэрүүд
 - b) Тоон болон чанарын судалгаа
 - c) Эрэгтэй, эмэгтэйгээр нь ялган харуулсан тоон өгөгдөл
 - d) Хүйсээр ангилсан мэдээлэл
4. Жендэрийн статистикийг шинж чанаруудад аль нь огт хамааралгүй вэ?
 - a) Мэдээлэл, тоон өгөгдөл нь жендэрийн асуудлыг тусгасан
 - b) Мэдээлэл, тоон өгөгдлийг хүйсээр ангилан цуглуулж, үр дүнг танилцуулсан
 - c) Эрэгтэй, эмэгтэйчүүд ижил тэнцүү тоогоор илэрхийлэгдсэн.
 - d) Мэдээлэл, тоон өгөгдөл нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн олон талт байдлыг хангалттай тусгаж, тэдний амьдралын бүхий л талыг хамарсан ойлголт, тодорхойлолтод үндэслэсэн.
5. Жендэрийн статистикийг хөгжүүлэхийг зорилго нь
 - a) Тэгш бус байдлыг арилгах
 - b) Эмэгтэйчүүдийг дэмжих
 - c) Бодлогын сөрөг нөлөөллөөс сэргийлэх, бууруулах
 - d) Ядуурлыг бууруулах

Танд амжилт хүсье.

САНАА БОДЛОО ХУВААЛЦАХ, ОЙЛГОЛТОО НЭГТГЭХ

(10 минут)



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Англи хэл дээр:

UNECE (2010). Developing Gender Statistics: a Practical Tool, United Nations Economic Commission for Europe, World Bank Institute.

https://unece.org/DAM/stats/publications/Developing_Gender_Statistics.pdf

UNSD (2016). Integrating a Gender Perspective into Statistics, Studies in Methods, Series F No. 111 Department of Economic and Social Affairs Statistics Division, United Nations, New York

<https://unstats.un.org/unsd/demographic-social/Standards-and-Methods/files/Handbooks/gender/Integrating-a-Gender-Perspective-into-Statistics-E.pdf>

UN, ECLAC (2020). The importance of gender mainstreaming in statistics for the public policy development Overcoming gender data gaps in the Caribbean to accelerate the implementation of the SDGS

https://www.cepal.org/sites/default/files/presentations/the_importance_of_gender_mainstreaming_in_statistics_for_the_public_policy_development_.pdf

Монгол хэл дээр:

БСШУЯ, АХБ, 2017. Дээд боловсролд жендэрийн эрх тэгш байдлыг хангах нь” сургалтын гарын авлага, Улаанбаатар

Эрдэс баялаг эмэгтэйчүүдийн холбоо, 2020. Эрдэс баялгийн салбарын Жендэрийн сургалтын гарын авлага, хуудас 35. Монгол улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх төсөл, СЕСМИМ төсөл, Улаанбаатар

Цахим хуудас:

Дэлхийн банк. 2022. Цахим мэдээллийн сан. <http://databank.worldbank.org>

НҮБ. 2022. Цахим мэдээллийн сан, Жендэрийн тэгш бус байдлын индекс (<https://data.un.org/Default.aspx>),

Олон улсын хөдөлмөр эрхлэлтийн байгууллага. 2022. <https://ilostat.ilo.org/data/>

ҮСХ. 2022. Статистикийн нэгдсэн мэдээллийн сан, Тогтвортой хөгжлийн зорилгын шалгуур үзүүлэлтүүдийн тоон мэдээлэл. <http://1212.mn>

Жендэрийн үндэсний хороо www.ncge.gov.mn

